

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-39
1.Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох	7-12
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монголбанк дахь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай /	12-13
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	14-15
4.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	15-19
5.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	19-39

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Х.Баттулга;
Чөлөөтэй: Ж.Ганбаатар, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Энхтүвшин.*

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц хэлэлцэх асуудлын 6 дугаарт орсон Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт оруулж хэлэлцэх горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монголбанк дахь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Р.Сэддорж: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан, Ш.Бямбасүрэн, М.Мандхай нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын Ажлын албаны дарга А.Баттөмөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 4
Бүгд: 20
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Б.Мөнхсоёл нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 80.0 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

4.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын үүрэг гүйцэтгэгч С.Амарсайхан, Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга С.Ням-Эрдэнэ, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Г.Батзориг, Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Ууганбаяр, Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг, Сорьцын хяналтын газрын дарга Д.Бэхбат, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Тулгаа, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн, Хууль, эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга С.Оюунцэцэг, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Баярцэнгэл, Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа, Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн дарга Ч.Содном, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн ахлах зөвлөх Н.Мөнхзэсэм, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайдын үүрэг гүйцэтгэгч С.Амарсайхан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу хууль зүйн дүн шинжилгээ хийсэн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, С.Цэнгүүн, П.Батчимэг, П.Сайнзориг, О.Батнайрамдал, М.Мандхай, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайдын үүрэг гүйцэтгэгч С.Амарсайхан, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Санал хураалт явуулахад Улсын Их Хурлын гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул уг асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулав./16:41/

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 16 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 34 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Гишүүд байрлалаа эзлээрэй. Шууд санал хураалт эхэлнэ. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Алдаржавхлан, Бадамсүрэн, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Батшугар, Бямбасүрэн, Жаргалан, Лувсанжамц, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Цэнгүүн нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл Монгол банкин дахь баялгийн сангуудын зарцуулалт, үр дүнг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай. 2.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл Монголбанкны хэрэгжүүлж буй Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай. 3.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 4.Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ-аас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 5.Сэлбэ дэд төвийн нийгмийн хангамж болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Үндэсний аудитын газар, НЗДТГ болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох. 6.Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж өөр саналтай гишүүд байна уу? Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу? Өнөөдөр хэлэлцэх асуудлын хамгийн сүүл дээр орчихсон байгаа Улсын Их Хурлын даргын 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд танилцуулахаар бэлтгэсэн байгаа. Материалыг тараасан. Тэгээд хэлэлцэх асуудлын дараалалд хамгийн 1 дүгээрт оруулж өгөөд, санал хураалтыг түрүүлж яваад гишүүдийн ирц сайн байгаа үеэр танилцуулах хүсэлтэй байна.

Р.Сэддорж: Энэ нөгөө ажлын хэсгүүд байгуулахаа 1 дүгээрт эхэлж оруулсан нь дээр байх л даа. Шууд, шууд яачих юм чинь тийм ээ? Ингээд горимын саналаар

санал хураалт явуулъя. Лувсанжамц гишүүний гаргасан горимын санал 6 дугаарт, хэлэлцэх асуудлын 6 дугаарт байгаа асуудлыг 1 дүгээрт оруулъя гэсэн горимын саналтай байна. Энэ горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгож байна. Бэлтгэл, санал хураалтад бэлтгэе гишүүд, санал хураалтад бэлтгэе. Санал хураалт цуцлагдсан, санал хураалтад бэлтгэж байна. Бүгд хуруугаа уншуулсан байх ёстой. Лувсанжамц гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. 47,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Горимын санал гаргах юм уу? Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Уучлаарай, минийх сая нөгөө бэлэн байдалдаа ороогүй байсан болохлоор дэмжиж дарж чадсангүй. Тэгээд горимын саналыг санал хураалтын үр дүнг хүчингүй болгоод дахиж санал хурааж өгөхийг хүсье. Тэгээд миний танилцуулга бол удахгүй, маш товчхон, тодорхой та бүхэндээ 5, 10 минутын дотор танилцуулаад л дуусаж байгаа болохлоор хэдүүлээ гялс хэлэлцэж өгөхийг хүсье гэдэг тийм санал байна.

Р.Сэддорж: Дахиад санал хураалтад бэлтгэе гишүүд. Лувсанжамц гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал дэмжигдэж, санал хураалт хүчингүй боллоо. Гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Лувсанжамц гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудлын 6-д танилцуулагдсан Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцахыг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт эрэмбэллээ. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох

Хэлэлцэх асуудал 1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсгийг баримтлан Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах, танилцаж эхэлье. Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцыг ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Эрхэм гишүүдэд өдрийн мэндийг хүргэе. Горимын саналыг дэмжиж өгсөнд маш их баярлалаа. Тэгээд та бүхэндээ маш ойлгомжтой байх үүднээс манай Шижирмөнх зөвлөх миний явуулсан файлуудыг групп чат руу явуулаад өгчих үү бас, компьютер дээрээ харах хүмүүс нь хараад зэрэг явчихвал зүгээр гэж бодож байна. Өнөөдөр та бүхэнд танилцуулга болон үзэл баримтлал, ажлын хэсгийн санал, дүгнэлт, энэ ажлын хэсгээс гарсан Улсын Их Хурлын тогтоолыг та бүхэндээ танилцуулгаар тараасан байгаа. Та бүхэнд тайлбарлах нь болохлоор энд байгаа энэ өнгөтөөр хэвлээд гаргасан слайдыг та бүхэн маань анхаарлаа хандуулахыг хүсье.

Өнгөрсөн намрын чуулганаар байгуулагдсан энэ ажлын хэсгийн зорилго нь хот, суурин газрыг орон сууцжуулахад ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх холбогдох эрх зүйн орчныг сайжруулах гэсэн ийм зорилготойгоор ажилласан. Манай ажлын хэсэгт Ганбаатар гишүүн, Батшугар гишүүн, Болормаа гишүүн, Жангабыл гишүүн, Жаргалсайхан гишүүн, Мөнхбат гишүүн, Мөнхтулга гишүүн, Найдалаа гишүүн, Очирбат гишүүн, Соронзонболд гишүүн, Ундраа гишүүн,

Энхцэцэг гишүүн нар нэгдэж ажилласан. Энэ ажлын хэсгийн хугацаандаа бид албан байдлаар 11 удаа, албан бусаар 9 удаа, нийтдээ 20 удаагийн уулзалтыг олон талт байгууллагуудтай төрийн болон хувийн хэвшил, хувийн банкнууд, ногоон орон сууц барьдаг, амины орон сууц барьдаг ААН-үүдтэй, мөн дээрээс нь нэмээд мэргэжлийн холбоод, ялангуяа ногоон орон сууцын стандартыг боловсруулдаг Монголын Ногоон барилгын, Үндэсний ногоон барилгын хүрээлэн гэсэн байгууллагуудтай хийсэн.

Та бүхэн 4 дэх хуудсанд анхаарлаа хандуулна уу. Тэгээд сая хэлсэн байгууллагуудыг ямар зорилготойгоор ийм байгууллагуудтай уулзсан бэ гэхлээр эхлээд аливаа төсөл, арга хэмжээ, бодлогын бичиг баримт боловсруулахдаа эрэлт, нийлүүлэлт, чанар гэсэн ногоон өнгийн гурвалжин дээр та бүхэн анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Энэ байгууллагуудтайгаа уулзах, нөгөө талдаа хэрэглэгч, ААН, холбоод болон банк санхүүгийн байгууллагууд гэсэн цэнхэр өнгийн гурвалжин дээр нийт 6 талт оролцогч талуудыг бүгдэд нь хамруулаад ажлын хэсгийнхээ үйл ажиллагааг явуулсан. 1 дүгээрт нь, 5 дугаар хуудсан дээр асуудал бол агаарын бохирдол, орчны бохирдол, хүн амын өвчлөл, 2 дугаарт эрчим хүчний үрэлгэн хэрэглээ, дэд бүтцийн дутагдал, 3 дугаарт нь нийслэл Улаанбаатар хотод 170 мянга гаруй айл өрх, улсын хэмжээнд 300 мянган айл өрх стандартын бус дулаалгатай байгаа буюу эрчим хүчний хэрэглээ өндөр байгаад байгаа гэсэн ийм асуудал байгаа. Үүнийгээ нотолгоо болгож гаргасан зүйл бол судалгаанд оролцсон өрхүүдийн нэгдүгээрх нь 50 хувь нь байшин, гэрээ дулаалах сонирхолтой боловч ердөө 10 хувь нь л зээл авах боломжтой гэсэн нэг асуудал байна.

2 дугаарт нь ногоон зээлийн эзлэх хувь нь нийт хувийн банкнуудаас олгож байгаа ногоон зээлийн эзлэх 3,7 хувь байгааг бол 2030 он гэхэд 10 хувьд хүргэх ёстой гэсэн тийм Монголбанкны зорилт байгаа. Сүүлийнх нь санхүүгийн хөшүүрэг сул, мэдээлэл хангалтгүй гэсэн нөхцөл байдлын улмаас ногоон орон сууцын нийлүүлэлт, мөн эрэлт талыг нь дэмжих хууль, эрх зүй болон санхүүгийн хөшүүрэг байхгүй гэсэн тийм дүгнэлт гарсан. Шаардлагын хувьд ногоон барилгын стандарт өнгөрсөн жил Батсуурь сайдын ахалж байгаа Хот байгуулалтын яаман дээр Бест гэр гээд үндэсний стандартыг батлуулсан. Энэ хэрэгжилтэд нэвтрээд, хэрэглээг дэмжих, цаашдаа гэрийн дулаалгад мөн адил утааг гаргахгүй, цахилгаанаар хангах, халаах боломжтой эрчим хүчний хэмнэлттэй тийм Монгол гэрийн стандартыг боловсруулах ёстой болов уу гэсэн тийм шаардлага байгаа. 2 дугаарт нь санхүүжилтийн дэмжлэг, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах буюу төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулаад ногоон барилгыг барьдаг, зурдаг, төлөвлөдөг, төсөвлөдөг хувийн болон төрийн байгууллагуудын бүртгэл, дүгнэлтүүдийг нь нээлттэй, ил тод байдлаар байлгах ёстой гэсэн тогтолцооны асуудал яригдсан.

6 дугаар хуудсан дээр эрх зүйн орчны шинэчлэл дээр бид өнөөдөр танилцуулж байгаа Их Хурлын тогтоолын төсөл дээр ногоон болон уламжлалт барилгын ялгааг тодорхойлох, ялангуяа төлөвлөлт, зураг төсөл, материал, эрчим хүчний хэмнэлт, технологи гэсэн зүйлүүд дээр. 2 дугаарт нь ногоон барилгын шалгуурыг Барилгын тухай хуульд тусгаж, хөнгөлөлттэй ипотекийн зээлд ногоон барилгын шалгуурыг давуу нөхцөл болгон тусгах гэсэн ийм өөрчлөлт хэрэгтэй. 3 дугаарт нь хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт буюу MRV гэж байгаа. Олон улсад энийг хэрэгжүүлээд эхэлсэн, манай улсын хувьд хараахан бэлтгэгдэж амжаагүй байгаа гэсэн мэдээллийг Байгаль орчны яамнаас авсан. Энэ MRV үндэсний тогтолцоог бүрдүүлэх шаардлага байгаад байгаа. 4 дүгээрт нь гэр хорооллын

ногоон сууцын үнэлгээ, бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах гэсэн эрх зүйн орчны шинэчлэлүүд шаардлагатай байна.

2 дугаарт нь сая хэлсэн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах тал дээр 2.2.1 дээр стандарт баталгаажуулалт буюу сая хэлсэн ногоон барилгын Бест гэр стандартыг хэрэгжилтэд нэвтрүүлж, чанарын шаардлага хангасан ногоон хэрэглээг дэмжих. 2 дугаарт нь гэр дулаалгын шинэ стандартыг боловсруулж, баталж, үндэсний итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулах. 3 дугаарт нь стандартын шаардлага хангасан дулаалгын ажлыг урьдчилгаагүй, Батлан даалтын сангийн оролцоотой зээлээр санхүүжүүлэх гэсэн ийм стандартын нөхцөл сайжруулах хэрэгтэй байгаа.

2.2.2 дээр зээлийн нөхцөл, санхүүжилт дээр 1 дүгээрт нь эрчим хүчний хэмнэлтийн түвшнээр шаталсан хүүгийн урамшуулал олгох. Жишээлбэл хэрвээ тухайн байшингийн эрчим хүчний хэмнэлт нь 50 хувь байвал тухайн байшинг банкны ногоон зээлээр худалдан авах тохиолдолд зээлийн хүүг нь 50 хувиар бууруулж өгөх гэсэн ийм тогтолцооны шинэчлэлтийг хийх ёстой гэсэн санал байна. Түүний дараагаар Хэрэглээний ногоон зээлийн шинэ журам боловсруулж зээлийн хугацааг 5 жил ба түүнээс дээш тогтоох шаардлагатай байгаад байгаа. Энэ яагаад вэ гэхлээр өнөөдөр ногоон бүтээгдэхүүн худалдаж авах буюу байшин, гэрээ дулаалъя гэхээр хэрэглээний энгийн зээл буюу 30, 36 сараар зээлийн хугацаа нь гардаг. Тэгэхлээр сардаа төлж байгаа эргэн төлөлтийн хэмжээ нь их болоод төдийлөн сайн ногоон барилга байгууламж, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтэрч чадахгүй байгаад байгаа гэсэн ийм нөхцөл байгаа учраас илүү хөрөнгө оруулалтын чанартай зээлийн ангилалд орох ёстой гэсэн үндэслэлээр 5 жилийн хугацаа эсвэл түүнээс дээш хугацааг тогтоох ёстой гэсэн тийм санал байна.

3 дугаарт нь дулаалгын зээлийн эх үүсвэрийг 40 хувь, иргэдийн дулаалгын зээлийг зээлд 40 хувийг нь дулаалгын бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн эргэлтийн хөрөнгөд, 20 хувийг нь ногоон хэрэглээний бүтээгдэхүүнд зориулах гэсэн ийм өөрчлөлтийг оруулж байгаа. Энэ яагаад вэ гэхлээр өнөөдөр нийтдээ 1 их наяд орчим төгрөгийн ногоон эх үүсвэртэй банкин дээр ногоон зээл байгаа боловч үүний 80, 90 хувь нь цахилгаан автомашин болоод байгаа. Тэгэхлээр бид буцаад гаднаас хөнгөлөлттэй эх үүсвэрээ татсан энэ ногоон эх үүсвэрийг Монгол Улсад үлдэх хөрөнгө болгохын тулд, ялангуяа ийм үл хөдлөхийн ногоон барилгын энэ салбар луу чиглүүлэх ёстой учраас эрэлтийг дэмжих буюу хэрэглэгчдийг дэмжих дулаалгын зээл нь 40 хувь, дулаалгын үйл ажиллагаа эрхэлдэг эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьдаг ААН-үүдэд бизнесийн зээлд нь 40 хувь, үлдсэн 20 хувьдаа сая хэлсэн цахилгаан машин ч байдаг юм уу, эсвэл эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэглэлүүдээ худалдаж авах ийм боломжтой нөхцөлүүдийг оруулбал зүгээр юм болов уу гэсэн санал байгаа юм.

Дараагийнх нь орлогоо нотлох боломжгүй иргэдэд Зээлийн батлан даалтын сангийн оролцоотой зээл олгох гэсэн ийм зүйл байна. Одоогоор 60 сая төгрөгийн батлан даалтын сан байгаа нь барилга, орон сууц дээр төдийлөн сайн хэрэгжих боломжгүй жижиг байгаа учраас үүнийг нь ихэсгэх шаардлагатай гэсэн санал байна.

Сүүлийнх нь арилжааны банкнууд болон, банкнууд олон улсаас татсан ногоон санхүүжилтийг ногоон барилга, амины орон сууц, дулаалгын төсөлд 80 хувиас дээш хувь зарцуулсан тохиолдолд Монголбанкнаас своп хэлцлийн хүүгийн хөнгөлөлтийг нэмэгдүүлэх гэсэн ийм заалтыг оруулсан. Одоо олон улсаас

хөнгөлөлттэй ногоон санхүүгийн эх үүсвэрийг татахад 0,5 хувийн своп хөнгөлөлт үзүүлж байгаа. Гэхдээ энэ маань сая хэлсэнчлэн 80, 90 хувь нь цахилгаан машин болоод байгаа учраас эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, дулаалгын бизнест ийм зүйлүүдэд хэрвээ тухайн банк 80 хувиас дээш хөрөнгө оруулалт хийсэн, зээл олгосон байвал хөнгөлөлтийг нь нэмж өгье гэсэн ийм зохицуулалт байгаа. Санхүүжилтийн тогтолцоог сайжруулахын 3 дээр татварын бодлого байгаа. Хувь хүний орлогын албан татварт нэмэлт, өөрчлөлт оруулж, дулаалгад зарцуулсан хөрөнгө оруулалтад татварын буцаан олголтыг олгоё гэсэн ийм санал оруулж байна. Өнөөдөр орон сууц худалдан авах тохиолдолд 6 сая төгрөгийг иргэд төлсөн татвараасаа эргүүлэн буцааж авдаг бол байшин, гэрээ дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд мөн адил буцаан олголтыг нь адил хувиар явуулъя гэсэн тийм санал байгаа.

Дараагийнх нь Үндэсний ногоон барилгын стандартыг хангаж В болон түүнээс дээш үнэлгээ бүхий гэрчилгээтэй амины орон сууцыг худалдсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татварын хувь хэмжээг 2 хувиас 1 хувь болгон бууруулах буюу эрчим хүчний хэмнэлттэй орон сууцын зах зээлийг нэмэгдүүлэх, дэмжих, нийлүүлэлтийг дэмжих, цаашлаад утааг бууруулах гэсэн ийм зорилго руу чиглэж байгаа хөнгөлөлтийн тогтолцоог бий болгох нь зүйтэй болов уу гэсэн ийм зүйл байна. 2024 оны байдлаар нийт орон даяар 115 тэрбум төгрөгийг үл хөдлөх хөрөнгө борлуулсан орлогоос сая энд байгаа 2 хувийн татвараар авч байгаа бол үүнийг цаашдаа хэрвээ ногоон орон сууц байвал 50 хувиар хөнгөлж өгье гэсэн ийм зүйл байгаа.

Сүүлийнх нь ипотекийн хөнгөлөлт, ногоон зээлийн хүүгийн татаасыг зөвхөн утаагүй бүсэд хамаарах дэд төвүүд, дахин төлөвлөлтийн бүсэд хэрэгжиж буй төслүүдэд чиглүүлэх гэж байгаа юм. Өнөөдөр сүүлийн 2013 оноос хойш буюу сүүлийн 10 гаруй жил манай ипотекийн бодлого маань утааг бууруулах бодлоготойгоо уялдаж чадаагүй буюу ихэнх ипотекийн зээлийн хөнгөлөлтийн татаас маань Яармаг буюу Хан-Уул тал руугаа олгогдоод байгаа. Тэгэхлээр үүнийг нь эсрэгээрээ хот төлөвлөлтийн түвшинд утааг бууруулах бодлого нь ипотекийн бодлоготойгоо уялдаж байх ёстой гэсэн ийм санал байгаа. Зохицуулалт, төлөвлөлт дээр нийслэл болон хот, суурин газарт өрхийн цахилгаан халаалтын төлөвлөгөөг боловсруулах, цахилгаан хангамжийн хүчин чадал, шугам сүлжээний найдвартай байдлын үнэлгээг хийх гэсэн саналыг оруулсан. Өнөөдөр айл өрхүүд байшин, гэрээ дулаалаад утаа гаргадаггүй технологиор халаагуураа шийдье гээд тэгэхлээр эрчим хүчний эх үүсвэр нь 380-аар ирдэггүй, 220-оор ирдэггүй, айлууд тэрнээсээ болоод буцаагаад яндангаа, яндантай зуухаа оруулж ирээд, агаарын бохирдол дахиад үүсгэх нөхцөл байдал бий болоод байгаа учраас Эрчим хүчний яам талаасаа энэ зүйлүүдээ зохиц зохицуулж өгөх ёстой гэсэн төлөвлөлт дээр тодорхой тусгаад хаана тог тасрах вэ, хаана тог тасрахгүй гэдгийг тодорхой бодит болгож өгөх. Үнэхээр айл өрхүүд байшин, гэрээ дулаалаад утаа гаргадаггүй болбол эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангана гэдэг тодорхой байдлыг төр гаргаж өгөх ёстой гэсэн ийм зүйлийг оруулж өгсөн.

Удаах нь утаагүй бүсүүдийг орон нутгийн болон нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган шаардлагатай дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулах. Дараагийнх нь сайжруулсан шахмал түлшний татаасыг бууруулах, хэмнэгдсэн хөрөнгийг ногоон зээлийн хүүгийн татаасанд шилжүүлэх механизм журмыг боловсруулах гэсэн санал байгаа. Өнгөрсөн жил Тавантолгой түлш компани ойролцоогоор 200 гаруй тэрбум төгрөгийг сайжруулсан түлш дээр

татаас болгоод шатаагаад дуусгачихсан. Тэгэхлээр бид цаашдаа энэ хэрэглээг нь дэмжих биш, хэмнэлтийг дэмжих буюу хэрвээ та байшин, гэрээ дулаалаад, утаа гаргадаггүй болгочихвол үүнийх нь зээлийнх нь хүүг нь төрөөс татаас өгье буюу хэрэглээг дэмжих биш, хэмнэлтийг дэмжих бодлого руугаа шилжье. Ингэснээрээ утааг улсын хэмжээнд бууруулах ийм боломж, бололцоог нь санхүүгийн хөшүүргийг нь бий болгож өгье гэсэн ийм зорилготой байгаад байгаа юм.

Сүүлийнх нь Ногоон барилгын мэдээллийн сан үүсгэж, зураг, төсөл зохиогч, гүйцэтгэгчид нээлттэй болгох, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалттай барилгад ногоон стандарт мөрдөх журам батлах байгаа. Олон хүмүүс хэлдэг. Гэр суурин газартаа баригдаж байгаа байшин барилга дээр утаа гаргадаггүй стандартыг заавал батлах ёстой гэсэн санал манай ажлын хэсгийн хуралдаанд оролцож байсан иргэд болон ААН-үүдээс мэргэжлийн холбоодоос их санал гарч байсан тул энийг бодитоор тусгаж өгсөн. Цаашдаа бид гэр хороололд гэр суурин газарт барих гэж байгаа бол утаа гаргадаггүй технологиор байшин орон сууцаа барья, төрийн байгууллагууд ч гэсэн адилхан ногоон барилга руу шилжье гэсэн ийм саналыг оруулж байгаа юм.

11 дүгээр хуудсан дээр эдгээр энэ Улсын Их Хурлын тогтоолыг батлагдаад хэрвээ тусгагдсан зүйлүүд хэрэгжвэл утаа бодитоор хэрхэн буурах вэ гэсэн графикайг бүрдүүлж гаргасан байна. Энэ дээр 2025 оноос эхлээд 2032 он хүртэл сая дурдагдсан төсөл, арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлээд хөтөлбөрөө боловсруулаад гаргавал улсын хэмжээнд 300 мянга гаруй өрх, түүнээс нийслэлийн хэмжээнд 170 мянган өрх орон сууцдаа эрчим хүчний хэмнэлттэй утаа, хорт бодисын ялгарлыг бууруулах боломж бүрдэх буюу 2028 он гэхэд агаарын бохирдол 50-аас дээш хувиар буурах боломжтой. 2032 он гэхэд 80 хувиар хүртэл буурах боломжтой гэсэн ийм тооцоолол гарсан. Үүн дээр ягаанаар нь үзүүлж байгаа нь болохлоор түлшний татаасны зардал буюу бид одоо Тавантолгой түлш дээр өгч байгаа зардлыг ягаан өнгөөр чернилийн ягаан өнгөөр үзүүлж байгаа нь дулаалгын бодлогын зардалтайгаа харьцуулаад харбал бид 32 он хүртэл дулаалгыгаа дэмжиж явсан нь илүү утааг бууруулах боломжтой болно гэсэн ийм тооцоолол гарсан. Энэ тооцооллыг манай Цэвэр агаар эвсэл буюу сайн дурын залуучууд маань гаргаж өгөөд, тэндхийн Тэнгис гээд MIT төгссөн залуу тооцооллыг нь гаргаж өгсөн. Ташрамд дурдахад Тэнгистээ баярлалаа гэж хэлмээр байна.

Тэгээд улсын хэмжээнд эрчим хүчний хэмнэлттэй орон сууцын барилга, гэрийн дулаалга өргөжиж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдэнэ, амьдрах орчин сайжирна гэсэн ийм үр дүн хүлээгдэж байгаа. 12 дугаар хуудсан дээр сая хэлсэнчлэн өнөөдөр банкнуудын олгож байгаа ногоон зээлийн хувь нь нийт зээлийн 3,7 хувийг эзэлж байгаа бол 2030 он хүртэл 10 хувь болно. Тэгэхлээр энэ 10 хувийгаа хэдүүлээ дулаалгын бодлогод чиглүүлье, амины эрчим хүчний хэмнэлттэй орон сууцын бодлогод чиглүүлье гэсэн ийм зорилтуудыг тавьсан байна.

Ингээд хүлээгдэж буй үр дүнгийн 3 дээр ногоон санхүүжилтийн тогтолцоог ил тод тайлагнал, хяналт, санхүүжилт, гэрчилгээжүүлэлт, ногоон барилга болон бүтээгдэхүүн гэсэн энэ зүйлүүд дээр шат шатанд нь хэрэгжүүлээд явах ёстой гэсэн ийм зүйлийг үзүүлж байна. Тэгээд хамгийн сүүлийн хуудсанд та бүхэн анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Энэ ажлын хэсгийн үр дүнгээр бид манай ажлын хэсгээс Дулаанбаатар гэдэг аяныг эхлүүлж байгаа. Энэ Дулаанбаатар гэдэг аян бол та хэрвээ байшин, гэрээ дулаалбал, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдаж аваад утааг бууруулахад та хувь нэмрээ оруулаач. Тэгвэл та өөрөө

Дулаанбаатар болно, баатар болно гэсэн тийм агуулгатай. Мөн бид дулаалж байж л утааг бууруулах боломж нь бүрдэх юм гэсэн ийм уриалгатай аяныг эхлүүлээд 2028 он хүртэл сая хэлсэн агаарын бохирдлыг 50 хувиас дээш хүртэл бууруулах нөхцөлийг бий болгож өгөх энэ Их Хурлын тогтоолын төслийг та бүхэн маань дэмжиж, баталж өгөхийг хүсэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье? Тогтоолын төсөлтэй гишүүд сайн танилцаж амжаагүй байгаа тул дараагийн Байнгын хорооны хурал дээр оруулж, дахиж хэлэлцье. Нэгдсэн чуулганы тов дараалалд энэ тогтоолын төсөл ороогүй байгаа. Тийм учраас дараагийн Байнгын хороон дээр гишүүд санал, дүгнэлтээ боловсруулж ирээд дараагийн Байнгын хороон дээр хэлэлцье. Санал, дүгнэлттэй танилцаж дууслаа.

14.56 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудал 2.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэж эхэлье. Төслийг уншиж танилцуулъя. Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг сонссонтой холбогдуулан Монголбанк дахь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Бадамсүрэн, Батчимэг, Жаргалан, Энхтүвшин, Мөнхсоёл.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Эдийн засгийн байнгын хорооны дарга. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд, Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье? Алга байна. Гишүүд асуулт, Батсүмбэрэл гишүүн. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүний микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Саяын чиг үүргээ нэг тодруулаад уншаадаг даа та, саяын ажлын хэсгийнхээ.

Р.Сэддорж: Юуг гэсэн бэ?

Н.Батсүмбэрэл: Чиг үүрэг нь.

Р.Сэддорж: Монголбанкны 2024 оны санхүүгийн тайлан сонссонтой холбогдуулан Монголбанк дахь Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсэг. Микрофон дээр хэлчих. Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэлийн микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмэгдэж оръё.

Р.Сэддорж: Ингээд ажлын хэсэг, Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн гишүүн микрофон чинь нээлттэй байна. Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудад гээд найруулга дээр оруулах нь зөв байх. Яагаад гэвэл Хөгжлийн санг Монголбанкны дээр байхгүй гэж Монголбанкны Ерөнхийлөгч танилцуулга хийсэн шүү дээ. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан байгаа. Хөгжлийн сан манай төв банкны дээр байхгүй гэж хэлсэн учраас зүгээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудад гээд л оруулчихмаар байна. Тийм найруулгын санал тэгээд 1.

2 дугаарт нь ажлын хэсгийн гишүүд хуралдаандаа идэвхтэй оролцоорой. Ер нь ингээд манай Байнгын хорооны дарга энэ ажлын хэсгийн гишүүдийн оролцоог яг хэдэн удаа оролцсон бэ гэдгийг нэг дүгнэж, энэ 2 дугаар улирлын байдлаар гаргаж танилцуулаасай гэж хүсэж байна. Тэгэхгүй бол ямар хүндрэл гардаг вэ гэхээр нөгөө ажлын хэсгийн ирц бүрддэггүй. Тэгээд үүнээс болоод шийдвэр гарч чадахгүй хойшилж байгаа тохиолдлууд гардаг шүү гэдгийг зүгээр ажил хэрэгчээр л урьдчилж та бүхэндээ хэлж байгаа юм шүү. Түүнээс би ажлын хэсгийн ахлагч биш. Гэхдээ энэ тогтоолын төслийг санаачилсан. Тэгээд Батнайрамдал гишүүний ахалсан энэ ажлын хэсгийн ирц бүрдэх тал дээр анхаарч өгөөсэй л гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Найруулга дээр гишүүдийн оруулсан саналыг үндэслээд Монголбанк дахь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийх гэж орууллаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2 гишүүн нэмэгдэж орж байна. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, гишүүдээр Сэддорж, Бадамсүрэн, Батчимэг, Жаргалан, Мөнхтүвшин, Мөнхсоёл, Батсүмбэрэл, С.Сайнзориг нарын гишүүд, Батсүмбэрэл, Мөнхсоёл. Тэгье, сайн сонсож байгаарай. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Бадамсүрэн, Батчимэг, Жаргалан, Энхтүвшин, Мөнхсоёл, Батсүмбэрэл, Сайнзориг.

Гишүүд санал хураалтад бэлдье. Ажлын хэсгийг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. Ажлын хэсгийн дарга ирцээ хариуцна. Дарга нь. Байнгын хорооны дарга нийт гишүүдэд уриална. Тэгээд ажлын хэсгийн дарга яг өөрсдийнхөө ажлын хэсгийн ирцийг сайн хариуцахыг хүсье. Тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудал 3.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төв банкны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа орон сууцын ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, Ундраа, Сэддорж.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан зөвшөөрсүгэй. Эдийн засгийн байнгын хороо гэсэн ийм тогтоол байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье? Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Ипотекийн зээлийн хүртээмж нэлээн бага байгаа, яг оносон эзэндээ очихгүй байна. Эргээд энэ Улаанбаатар хотын дахин төлөвлөлт гэдэг юм уу, яг энэ төлөвлөлт, суурьшлын бүсийг дахин төлөвлөж байгаа энэ хэсгүүд рүү ипотекийн зээл бодлогынх нь дэмжлэг очихгүй. Зөвхөн commercial гэдэг юм уу яг ийм зүйл рүү илүү энэ зээлүүд олгогдоод байгаа энэ зүйлүүд байна.

2 дугаарт яах вэ энэ ипотекийн зээлийн нэг шалгуур дээр нь хэмжээ дамжаа тавьчихсан ч гэдэг юм уу, маш олон зүйлүүд иргэдээс санал ирдэг. Тийм учраас энэ ажлын хэсэгт нийслэлээс сонгогдсон гишүүний хувьд орж ажиллая гэж бодож байна. Ажлын хэсэгт нэмж оруулж өгөхийг хуралдаан даргалагч, Байнгын хорооны даргаас хүсэж байна. Батсүмбэрэл гишүүн нэмэгдье гээд хажууд хэлж байна. Та протоколд өөрөө хэлэх үү? Батсүмбэрэл гишүүн бид 2-ыг нэмж ажлын хэсэгт оруулж өгнө үү Байнгын хорооны даргаа.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүний гаргасан горимын саналын дагуу, Алдаржавхлан гишүүн, Алдаржавхлан гишүүний микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: Энэ ийм учиртай ажлын хэсэг юм Сайнзоригоо. Ерөнхийдөө та зөв олж харсан байна. Ер нь ипотекийн зээлийн энэ эрэлт, нийлүүлэлтийг ер нь уялдаж байгаа юм уу, үгүй юм уу орон сууцынхаа тэрийг үзмээр байгаа юм.

2 дугаарт янз бүрийн ипотекийн зээлийн дийлэнх нь нэг хүний тойрог руу явсан байна энэ тэр гэсэн мэдээ энэ тэр байдаг юм, тийм тэр энэ тэрийг үзэж харъя гэсэн бодол байгаа юм. Зүгээр яах вэ хэн нэгний мууг үзэх гээгүй шүү, зүгээр тийм асуудлууд зөндөө ирдэг. Тэгээд ер нь ипотекийн зээлийн асуудал манай энэ орон сууцынхаа барилгын нийлүүлэлтээс ер нь давчхаад байна уу? Давбал үнэ өснө

тийм ээ, тэрэнтэй уялдуулж харъя гэсэн ийм зорилгоор ажлын хэсэг анхлан байгуулах санал гаргасан юм.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2 гишүүн нэмэгдэж байна. Дахин ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, Ундраа, Сайнзориг, Батсүмбэрэл, Сэддорж. Бямбасүрэн гишүүн саналаа микрофон дээр хэлье.

Ш.Бямбасүрэн: Ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байгаа тул оруулж өгнө үү.

Р.Сэддорж: Мандхай гишүүн саналаа хэлье.

М.Мандхай: Би бас ажлын хэсэгт орж ажиллах саналтай байна, саналыг хүлээж авна уу.

Р.Сэддорж: Ингээд сая дурдагдсан ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарыг нэмээд. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье. Дахиад бэлдэх үү? Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлдье. Даваагийн Цогтбаатар гишүүн өмнөх, энэний өмнөх ажлын хэсэг дээр орьё гэсэн ийм хүсэлтээ ирүүлсэн юм байна. Би утсыг нь аваагүй юм байна. Энийг гишүүддээ дуулгая. Ажлын хэсэг, тэгээд 9 болж байна уу? Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

15.11 цаг

Дөрөв.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал 3, 4. Хэлэлцэх асуудал 4.Хот байгуулалт байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: Монгол Улсад Хот байгуулалтын тухай хууль 1998 онд анх батлагдаад, 2008 онд шинэчлэгдэн батлагдсан байна. Энэ хууль нь тухайн үеийн нөхцөл байдал, төвлөрөл багатай хүн амын байршлыг харгалзан үзэж, хот байгуулалтын үйл ажиллагааг ерөнхий төлөвлөлт, зураг төслийн түвшинд ерөнхий архитектурт төвлөрүүлэх тийм зорилготой хуулиуд батлагдаж, одоо хэрэгжээд явж байгаа. Сүүлийн 20 гаруй жил Улаанбаатар хотын хүн ам 2 дахин нэмэгдсэн ч хот төлөвлөлтийн хариуцлага бүхий эрх зүйн зохицуулалт нь одоо цаг үеийн шаардлагаа хангахгүй байгаа юм. Тэгээд үүний улмаас сургууль, цэцэрлэгийн

хүрэлцээ муудсан, нийгмийн үйлчилгээ, ногоон байгууламж, дэд бүтцийн хангамж алдагдаж, иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Бидний хувьд хүртээмжтэй, чанартай боловсролын талаар олон асуудлыг хөндөж ярьдаг хэдий ч түүнийг бүрдүүлэх шаардлагатай эрх зүйн орчныг орхигдуулсан байгаа юм. Тэгээд үүний улмаас сургууль, цэцэрлэггүй сургууль, цэцэрлэг төлөвлөсөн ч түүнийгээ хэрэгжүүлдэггүй тийм хотхон хорооллууд маш их байгаа. Жишээ нь Баянгол дүүрэгт Алтай гээд хотхон байдаг 2008 онд ашиглалтад орсон, 5200 айлтай, 16 мянган хүн амьдарч байгаа хэр нь нэг ч сургууль, цэцэрлэгийг төлөвлөөгүй асуудлыг бүрэн хаясан байгаа. Мөн жишээ нь нийслэлийн Эрин гэж хотхон, Хархорин гэж хотхонд 3500 хүүхэдтэй мөртөө нэг ч сургууль төлөвлөөгүй, нэг ч цэцэрлэг байдаггүй. Зөвхөн ашгийн төлөө барилга орон сууцаа бүх газарт нь төлөвлөсөн байгаа. Хан-Уул дүүрэгт хамгийн сүүлд King tower гэж их том хотхон баригдаж байгаа, 2 мянга орчим хүүхэд сургуулийн насны хүүхэд байгаа, 970 цэцэрлэгийн насны хүүхэд байхад тэнд ямар ч улсын сургууль, цэцэрлэг байхгүй.

Тэгээд Үндэсний статистикийн хорооноос надад өгсөн мэдээллээр Улаанбаатар хотод мянган өрх тутамд 2662 сургуулийн насны хүүхэд байна гэж байгаа юм. Мянган өрх тутамд шүү. 250 өрх тутамд 400 орчим цэцэрлэгийн насны хүүхэд байна гэж байгаа юм. Ийм учраас миний хувьд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах хуулийн төслүүдийг санаачлан боловсруулсан юм. 1 дүгээрт Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2-т нь Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, мөн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль гэсэн 5 хуулийг санаачлаад өнөөдөр өргөн барьж байгаа.

Энэ хуулийн зорилго нь хотхон, хороолол барихад сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах, заавал төлөвлөхийг хуульд оруулж өгөхгүй бол ганцхан Ерөнхий архитектур гэдэг хүн дураараа төлөвлөж байгаа юм өнөөдөр. Тэр хүн нэг норм дүрэм гэж барьдаг, таньдаг хүндээ сургууль, цэцэрлэгтээ зурж өгдөггүй, таньдаггүй улсууддаа сургууль, цэцэрлэгийн асуудлыг хатуу тавьдаг. Ийм байгаа учраас Хот байгуулалтын хуульд өөрчлөлт оруулж сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр энэ хуулийн заалтуудыг оруулсан. Энэ хуулийг өргөн барьж байна. Энэ хууль батлагдвал Монголын хүүхдэд маш их хэрэг болно гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. НЗД-ын Эдийн засаг, эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Даваадалай, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын Ажлын албаны дарга Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Сайнбаяр нар хүрэлцэн ирсэн байна. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Байгаа, тийм үг хэлнэ дараа нь. Алга байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, уучлаарай ирцээрээ Бадамсүрэн гишүүн үг хэлэх юм байна.

М.Бадамсүрэн: Энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлье. Яагаад гэхээр хамгийн сайн сургууль, цэцэрлэг бол гэртээ ойр сургууль, цэцэрлэг

гэдэг. Тэгээд энэ үүднээсээ хотхон хорооллыг сургууль, цэцэрлэгтэй байхаар төлөвлөх хуулийн ийм зохицуулалтыг заавал биелүүлэх шинж чанартайгаар ингэж хуулийн нэмэлт, өөрчлөлт болгож оруулж байгаа нь их зөв гэж бодож байгаа. Харин ч энэ асуудал их оройтож орлоо. Тэгээд энэ хуулийн төслийг санаачилсан Алдаржавхлан гишүүнд талархсанаа илэрхийлье.

Дээр нь цаашдаа энэ сургууль, цэцэрлэгээс гадна энэ гадна зогсоол, ногоон байгууламжтай холбоотой стандарт дээр хуульчлах шаардлагатай гэж байр сууриа илэрхийлж байна. Учир нь Хот байгуулалтын тухай хууль дээр 70, 30 гэсэн харьцаа байсныг 60, 40 болсон. Өөрөөр хэлбэл нийт эзэмшил газрынхаа яг барилгажих хэсэг нь 60 хувь, 40-өөс доошгүй хэсэгт нь ногоон байгууламж, авто зогсоол байгуулна гэж. Тэгээд энийг тодорхой уян хатан, тодорхой ийм тухайн орон сууцад амьдарч байгаа айл өрхийн тоо болон тэр барилгын метр квадрат, худалдаа, үйлчилгээний байгууллагууд бол метр квадратаас нь хамааруулж энийг уян хатан тогтоох шаардлага зүй ёсоор урган гарч байгаа. Яагаад гэхээр одоо энэ мөрдөгдөж байгаа 70, 30 гэдэг ч байсан, одоо ч 60, 40 гэж байгаа стандарт үндсэндээ социализмын үеийн 5 давхар барилгаар ойролцоогоор тохируулж хийсэн тийм харьцаа байгаа. Гэтэл одоо бол үндсэндээ барилга маань хамгийн бага нь л үндсэндээ 9 давхар, тэгээд л дээшээ 16, 20, 30 давхар болж өндөр баригдаж байгаа учраас тэнд илүү олон айл өрх амьдарч, илүү олон байгууллагууд худалдаа, үйлчилгээ явуулж байгаа учраас гадна талд нь зогсоол, ногоон байгууламжийн энэ стандарт шаардлага үндсэндээ энэ цаг үеийн хөгжил, өндөр барилгачидтайгаа холбоотой энэ нийцэхгүй болж байгаа ийм л дүр зураг гараад байгаа юм.

Тийм учраас энийг цаашид хуульчлах шаардлагатай зүйл нь авто зогсоолыг В1, В2 гээд ингээд суурийн давхраас доош хэмжээнд нь оруулсныг харьцуулж тооцох. Энэ чиглэлээр манай Сайнзориг гишүүн гэхэд энэ дээр тодорхой зохицуулалтыг боловсруулж байсан юм байна лээ. Тэгээд энэнтэй санал нэг байгаа. Мөн үүнтэй, үүнээс бусад ногоон байгууламжийн хувьд энэ ингэж дүйцүүлэх боломжид хязгаарлагдмал. Тийм учраас энэ анхнаасаа газар олгохдоо өөрөөр хэлбэл төлөвлөлтөө хийхдээ гадна талынх нь талбай нь өндөр барилга барих бол тэрийгээ дагаад тодорхой харьцаагаар ингэж гадна ногоон байгууламж, авто зогсоолын хэмжээ нь нэмэгддэг байхаар ингэхгүй бол үндсэндээ энэ өндөр барилга бариад л байвал төв суурин газрын түгжрэл хэзээ ч арилахгүй. Зам нь болохоор ингээд ялгаа байхгүй нөгөө элсэн цаг шиг ингээд нэг газраа өргөн байсан ч гэсэн тэр орон сууцынхаа хорооллууд дээр эсвэл орон сууцнаас орж, гарч байгаа хэсэг дээрээ нарийхан болчихоор ингээд л үндсэндээ түгжрэл арилахгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ бол ийм гинжин холбоотой, хотын авто автомашины хөдөлгөөн гэдэг ийм гинжин холбоотой хөдөлгөөн байгаа учраас энэ том асуудал.

Дараагийнх нь энэ явган замтай холбоотой асуудлыг бас тодорхой ийм зохицуулалттай болгож өгөх зайлшгүй шаардлагатай байгаа. Яах вэ стандарт байдаг Монгол Улсад 1,5 метрээс доошгүй өргөнтэй буюу 2 хүн зөрөх хэмжээнд байхаар заасан. Гэтэл энэ мөн л тэр хот, суурин газрынхаа хүн амын тоо, тэр хотхоныхоо тооноос хамааруулаад энийг энэ Стандартын хуулийг энэний дараа хэлэлцэх юм байна лээ. Тэгэхээр энэтэй уялдуулж яг цаашид энэ чиглэлээр хуулийн төсөл санаачилга шаардлагатай байна гэж үзэж байгаа. Тэгээд энэ нь хамгийн том сургууль, цэцэрлэг, хүүхдийн боловсролд анхаарсан энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаагаа дахин илэрхийлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг үг хэлнэ.

П.Сайнзориг: Би энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж үг хэлж байгаа юм. Ерөөсөө хот гэдэг зүйл органик зүйл байгаа. Энэ эдийн засгийн таталцал байдаг юм уу, ажлын олдоц, амьдралын чанарт нөлөөлж байгаа энэ орчноосоо шалтгаалаад хот руу тэмүүлдэг үзэгдэл манай улсад нэлээдгүй байсан. 1990-ээд оны дундуур өмч хувьчлалын дараагаар орон нутаг дахь үйлдвэр заводууд хаагдсан, гамшиг, зудын шалтгаалаад малчид өрхийн орлого малаа барсан зэргээс шалтгаалаад хот руу нүүдэллэх нүүдэл байсан. Энэ хүрээндээ бид энэ хот төлөвлөлтийг өнгөрсөн 20-иод жилийн хугацаанд ерөнхийдөө алдсан. Энийг бага багаар засах, засахдаа нэлээн өртөгтэй засаж байгаа юм. Тэгэхээр энэ хууль энэ асуудлыг нэлээн цэгцлэх, цэгцлэх цэгцлэхдээ хүний анхан шатны хэрэгцээ буюу хүний эрхийг хангах чиглэлд нэлээн суурь түлхэц болно гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр хот төлөвлөлт гэдэг бол ерөөсөө л хүний эрхийг хангах механизм байхгүй юу. Тэгэхээр манайхны сэтгэхүй болохоор хот гэхээрээ нэг ийм байшин барилгын тухай яриад байдаг боловч хот төлөвлөлтийн цаана хүн яаж стрессгүй амьдрах вэ, зардал багатай амьдрах вэ, илүү их гэр бүлдээ цаг гаргадаг, гэр бүлийнх нь гишүүн болох үр хүүхдүүд нь аюулгүй сургууль, цэцэрлэгт зорчдог энэ орчныг бүрдүүлэх тухай л байгаад байгаа юм. Тэгэхээр энэ концепод энэ хууль бүрэн нийцэж боловсруулагдсан байна гэж гишүүний хувьд үзэж байгаа. Тийм учраас хэлэлцэхийг дэмжиж байна.

Ер нь сургууль, цэцэрлэг, эмнэлэггүй ийм суурьшлын газрууд бий болсноор ерөөсөө л тэндэх хүний эрхийн зөрчил дээд цэгтээ тулж байгаа. Өрхийн, өрх дээр ирэх зардал нэмэгдэж байгаа. Заавал сургууль, цэцэрлэгээ хол зайд хүүхдээ хүргэж өгнө гэдэг машин авна, өвдөж хавдлаа гэхэд эмнэлгийн яаралтай тусламж авахад хүртэл саатна ч гэдэг юм уу, энэ маш олон ийм сөрөг үзэгдлүүд гардаг. Тийм учраас энэ асуудлыг шийдээд явж байгаад нь талархалтай байна. Тэгээд ер нь цаашдаа Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль энэ тэрийг нэг иж бүрнээр нь авч, энэ асуудлыг нэг ултай суурьтай, газрыг яг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа ямар эрэмбэ, дэс дараатай зарчмаар хандах юм. Энэнийхээ нэг хэсэг болох газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах харилцаа чинь ерөөсөө энийг хот, суурин газар байгуулах асуудал байгаа юм. Энэ дээрээ ямар зарчим, төлөвлөлтөө барьж ажиллах юм бэ гэдэг зүйлийг хууль, эрх зүйн хүрээнд маш тодорхой болгох ёстой гэдэг зүйлийг би зүгээр зарчмын хувьд протоколын хувьд хэлж байна. Энэ хууль бол эхний нэг суурь алхмыг тавихад чухал хууль болов уу. Тэгээд хэлэлцээд явахыг дэмжиж байна. Ажлын хэсэг гарах болов уу, яадаг юм бол зүгээр сайн мэдэхгүй байна. Энийг Байнгын хорооны дарга чиглүүлж, зохион байгуулж өгөөсэй гэж хүсэж байна. Тэгээд хэлэлцэхийг дэмжиж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд дахин санал хураалтад бэлдье. Дахин хуруугаа уншуулна. Бүгд болсон уу, бүгд болчихсон уу?

Санал хураалт 1. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

2 хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

3 хамт өргөн мэдүүлсэн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

4 хамт өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Өмнөх санал дээр Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. 4 дэх санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

5 хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын гишүүн, Бадамсүрэн гишүүн, чуулганаар уу? Тэгье. Чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа ирэх долоо хоногийн хурал дээр Ажлын хэсэг байгуулах тухайгаа хэлэлцье. Санал хураалт явуулж дууслаа. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

15.28 цаг

Тав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 5. Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын үүрэг гүйцэтгэгч Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

С.Амарсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, Хууль тогтоомжийг 2024-өөс 28 онд боловсронгуй болгох үндсэн чиглэлд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг шинэчлэх шаардлагыг онцгойлон заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжаар стандарт, тохирлын үнэлгээний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх үүрэг хүлээлгэсэн билээ. Өнөөдөр бид дэлхийн эдийн засаг, худалдааны өрсөлдөөн, аюулгүй байдлын шинэ нөхцөл байдалд ажиллаж, амьдарч байгаа. Иргэдийн аюулгүй байдал, тэр дундаа амьдралын суурь хэрэгцээ,

амьдралын чанарыг сайжруулах, хэрэглээний аюулгүй байдлыг хангах, үндэсний үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж, экспортын бараа, бүтээгдэхүүний төрөл зүйлийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд нийлүүлэх, стандартын тогтолцоогоо эрс шинэчлэх шаардлагатай байна.

2017 онд батлагдсан одоогийн хуульд стандартыг зөвхөн сонгон хэрэглэх гэж заасан нь иргэн, ААН төрийн хяналтын байгууллага хооронд ойлголтын зөрөө, хэрэгжилтийн тодорхойгүй байдал, мөн хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ноцтой эрсдэл учруулж байгаа зэрэг амьдрал дээрх олон хүндрэл, бэрхшээл бий болж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 6733 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч тэдгээрийн хэрэгжилт сул, мөрдөх хэвшил, хэрэглээ, соёл сул, тогтолцоо бүрэн бүрдээгүй хэвээр байна. 2022 онд Шадар сайдын тушаалаар хийгдсэн судалгаагаар 2 мянга гаруй стандартад дүн шинжилгээ хийхэд зөвхөн 20 гаруй хувь нь шаардлага хангаж байгаа. 20 орчим хувь шинэчлэн батлагдсан, үлдсэн 80 хувийг бид шинэчлэх ёстой, шинээр батлах ёстой, олон улсын болон үндэсний стандартуудад нийцүүлж өөрчлөх ёстой гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

Энэ нь эрүүл мэнд, барилга, хүнс, аялал жуулчлал зэрэг стратегийн салбарууд төдийгүй, олон улсын хөгжил дэвшлээс ч хоцрох, хөгжлийн асуудлуудаас хоцрох, чанар, аюулгүй байдлыг хангах чадамжгүй болох ноцтой аюултай нүүр тулж байгааг бидэнд харуулж байгаа. Бүх салбарт стандарт мөрдөгдөхгүй, мөн хэвшээгүйгээс болж өнөөдөр Монгол Улс чанар стандарт, аюулгүй байдал гэдэг зүйл бүх салбарт онцгой анхаарал татсан ийм байдалтай байгаа. Тийм учраас энэ хуулийн шинэчлэлийг зайлшгүй хийх ёстой гэж үзэж бид хуулийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг оруулж ирж байгаа.

Тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн тогтолцоонд ч гүнзгий доголдол үүссэн гэж дүгнэж байгаа. Жишээлбэл эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 400 орчим лабораториос ердөө 35 нь өнөөдөр шаардлага хангасан байна гэж үзэж байгаа юм. Стандартын шаардлага хангасан 35-хан лабораторитой байхад бид хорт хавдаргүй байх тухай ярих боломжгүй. Эрүүл мэндийн стандарт, үйлчилгээ оношилгооны чанар, хурд, олон улсын түвшний асуудлыг ярих ямар ч боломжгүй. Цаашилбал энэ хүнсний лабораторийн 35-хан хувь нь итгэмжлэгдсэн лаборатори байна гэж үзэж байгаа юм. Томоохон үндэсний үйлдвэрлэгчид зарим нэг стандартын шаардлага, олон улсын шаардлага хангасан үйлдвэрлэлүүдээс бусад нь итгэмжлэлийн шаардлага хангахгүй, чанар, стандарт, аюулгүй байдлын нөхцөлийг бүрдүүлэхгүй байна гэсэн үг. Үүний улмаас бид эрүүл мэнд, аюулгүй байдал, тэр дундаа хүнсний аюулгүй орчин, аюулгүй хүнс хэрэглэх орчны нөхцөл байдал бүрдэх, үндэслэлтэй баталгаатай мэдээлэл ч бүрэн байхгүй байгаа.

Монгол Улсын хэмжээнд байгаа лабораториуд өнөөдөр бүх чиглэлээрээ өөрсдөө салбар салбарынхаа чиглэлээр асуудал ярьдаг. Аль нь ч орчин үеийн шаардлага хангасан ийм, ялангуяа төрийн байгууллагуудын харьяа лабораториуд тоног төхөөрөмж, бааз суурь асуудлууд нь тодорхой хэмжээнд бэхжээгүй гэж үзэж байгаа. Тэгэхээр бид эдгээрт бодитой дүгнэлт хийж, нөхцөл байдал, энэ нөхцөл байдлын хүрээнд бид стандартын эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагыг олон талаас нь судалж, 60 гаруй хэлэлцүүлгийг өнгөрсөн хугацаанд зохион байгууллаа. Давхардсан тоогоор 20 мянга орчим оролцогчоос 17250 санал авч, мөн энэ хуулийн шинэчлэлд тусгах асуудлуудыг зохион байгуулж ажиллалаа. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өнөөдөр та бүхэнд танилцуулж байна.

Энэ хуулийн төсөлд онцолж тусгах, анхаарах асуудлууд юу байсан бэ гэхээр 1 дүгээрт стандартыг зөвхөн сонгож хэрэглэх биш, дагаж мөрдөх үүрэг болгон хуульчлах шаардлага байна гэж үзэж байгаа. 2 дугаарт нь хяналт, зохицуулалтын тогтолцоог сайжруулж, олон улсын итгэмжлэл, баталгаажуулалтын системд бид нийцүүлэх шаардлага байна гэж үзсэн. 3 дугаарт нь цахим шилжилт, хиймэл оюун ухаанд суурилсан стандартын үйлчилгээний шинэ шат руу шилжих суурийг энэ хуульд тавьж өгнө. 4 дүгээрт нь үндэсний болон олон улсын стандартыг нутагшуулах, хэрэглэх нөхцөлийг илүү уян хатан бөгөөд гадаад худалдааг дэмжих боломж нөхцөл бүрдэнэ. Энэ хуулийн төсөл өөрөө 8 бүлэгтэй, 36 зүйлтэй. Үндсэн үзэл баримтлал нь стандартаар дамжуулан салбарын бодлогыг хэрэгжүүлж, зохицуулалт, хяналтыг илүү боловсронгуй болгох, Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хамгийн гол нь хүний эрүүл мэнд, орчны аюулгүй байдал, цаашилбал өрсөлдөх чадвартай иргэн, өрсөлдөх чадвартай улсыг бий болгох хамгийн гол тогтолцоо энэ гэж үзэж байгаа.

Бид хууль баталдаг, бодлого боловсруулдаг, зорилго тавьдаг. Харамсалтай нь тэр бодлого, зорилгодоо хүрэх гүүр нь болсон стандартыг орхигдуулсан, энэ салбарыг эзэнгүйдүүлсэн. Түүнээс үүдээд салбар бүр ундуй сундуй болсон гэдгийг та бүгд надаар хэлүүлэлгүй бүгдээрээ мэдэж байгаа байх гэж бодож байна. Хуулийн төсөл батлагдсанаар тооцоо баталгаатай, үнэлгээнд үндэслэсэн бараа, бүтээгдэхүүн мөн хилийн хяналтаар нэвтрэх боломж нөхцөл илүү бүрдэнэ. Ялангуяа импортоор орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн. Мөн дотоодын үйлдвэрлэл, бараа, бүтээгдэхүүний чанар, стандарт, хэрэглэгчийн аюулгүй байдал хангагдах боломж нөхцөл бүрдэнэ. Гадаад зах зээлд түрүүн хэлснээр өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Үүнийг дагаад нэг чухал асуудал бол хүн бүрийн толгойны өвчин болсон хүнд суртал, авлигын эрсдэл, асуудал буурна. Төрийн үйлчилгээний хүртээмж ил тод байдал улам нэмэгдэнэ гэж ингэж үзэж байгаа.

Ингээд эрхэм гишүүд та бүхэн энэ Монгол Улсын өнөөдөр зөвхөн хууль тогтоомжийн шинэчлэлийн бус, соёлын шинэчлэл, сэтгэлгээний шинэчлэл, хэрэглээний соёл, хэвшил шинэчлэлийг хослуулж хийх хамгийн чухал суурь болсон энэ стандартыг цаасан дээрх баримт бичиг гэж бас ард түмний эрүүл мэнд, амь нас, үндэсний аюулгүй байдлын баталгаа гэж үзэж, шинэчлэл өөрчлөлтийг боловсруулсан энэ хуулийн төслийг хэлэлцэж, нийгэмд шинэ хандлагыг бий болгох, төрийн үйлчилгээний шинэ соёлыг бий болгох, хувийн хэвшил, иргэдийн дунд үйлчилгээний соёл, аюулгүй байдлыг ч төлөвшүүлэх ийм боломж бүрдүүлэх хуулийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Товчхон танилцуулахад ийм байна. Асуултыг холбогдох байгууллагынхан энд байгаа учраас хариулаад явна. Баярлалаа.

Р.Сэддорж: Шадар сайдад баярлалаа. Хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Тамгын газрын Тэргүүн дэд дарга Чойжилсүрэнгийн Ариунхур танилцуулна. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон нээе.

Ч.Ариунхур: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя. Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46.5.5, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 34.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, мөн хуулийн 34.1.1-ээс 1.6 дахь заалтад заасан асуудлын хүрээнд хууль зүйн дүгнэлтийг гаргалаа.

Нэг.Төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцсэн эсэх, хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдсөн эсэх, тухайн төсөл, түүний зарим зүйл, хэсэг, заалтын зохицуулалтын хэрэгжих боломж, харилцан хуралдааны талаар. 1.Монгол Улс тариф худалдааны тухай 1994 оны ерөнхий хэлэлцээр болон Дэлхийн худалдааны байгууллага байгуулах хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, нэгдэн орсон. Уг хэлэлцээрийн хавсралтаар баталсан Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн энэхүү хэлэлцээрийн зорилгоор хэрэглэгдэх нэр, томьёо, тэдгээрийн тодорхойлолт гэсэн хавсралт нэгд эрх бүхий байгууллагаас баталж гаргасан бүтээгдэхүүн буюу түүний боловсруулалт үйлдвэрлэлийн аргуудтай холбогдолтой хэвийн нөхцөл болон олон удаа хэрэглэх дүрэм журам, дүрэм заавар буюу тодорхойлолтыг агуулсан заавал биелүүлэх шаардлагагүй баримт бичгийг стандарт гэж ойлгохоор нэр томьёоны тодорхойлолт өгчээ. Иймд хэлэлцүүлгийн шатад энэхүү заалтыг анхаарч үзэхийг хүсэж байна.

2.Төслийн 5.7 зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан техникийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно гэж зааснаас өөрөөр зөвшөөрөлтэй холбоотой тодорхой зохицуулалтыг төсөлд тусгаагүй нь хууль хэрэглээний явцад тодорхойгүй нөхцөл байдал бий болгож, хийдэл үүсгэж болзошгүй байгааг хэлэлцүүлгийн шатад анхаарна уу.

3.Төслийн 8.1-д хотын удирдлагаас хуульд заасны дагуу хотын стандартыг батлан хэрэглэнэ гэжээ. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д хотын зөвлөл болон хотын захирагчийг хотын удирдлага байхаар заасан бөгөөд төслийн 8.1-д зааснаар хотын стандартыг хотын удирдлага батлахаар ерөнхий байдлаар томьёолох нь эдгээр байгууллага, албан тушаалтны хувьд чиг үүргийн давхардал үүсгэж болзошгүй байна. Түүнчлэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21.1.3-д зааснаар нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах эрх нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд байгааг анхаарч, хэлэлцүүлгийн шатад хотын стандартыг ямар субъект батлахыг тодорхой болгох шаардлагатай байна.

4.Төслийн 25.1-д Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн гэж заасан. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1.2-т хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох үйл ажиллагаа явуулахыг агентлагийн үйл ажиллагаанд хориглосон. Төслийн 26.1.8-д Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллагын чиг үүрэгт хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх гэж тус байгууллагын хуулиар хориглосон чиг үүрэг, арга хэмжээг хамаарч ойлгогдохоор заасан байна. Түүнчлэн төслийн 23.1.5-д энэ хуульд заасан төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан тогтоох эрхийг тухайн асуудлыг эрхэлсэн ЗГ-ын гишүүнд олгох нь төслийн 26.1.8-д заасан төрийн захиргааны байгууллагаас хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх асуудалд хамаарахаар бол энэ нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3.1-

д заасан төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ гэсэнтэй болон мөн хуулийн 6.1-д заасан энэ хуулийн 6.2, 6.3-д зааснаас бусад тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуулиар тогтооно гэсэнтэй тус тус зөрчилдөж болзошгүйг анхаарч, хэлэлцүүлгийн шатад нягтлахыг зөвлөж байна.

5.Төрийн хяналт шалгалтын тухай хууль нь төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх... харилцааг зохицуулсан суурь хууль юм. Төслийн 29 дүгээр зүйлээр төрийн хяналт шалгалтын харилцааг зохицуулах тохиолдолд Төрийн хяналт шалгалтын хуулийн холбогдох зохицуулалтыг эшлэх замаар хуулиудын уялдааг хангаж бичих нь хууль зүйн техникийн хувьд нийцэхээр байна. Түүнчлэн төслийн 29.1-д заасан улсын байцаагч тус хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх, ямар эрх, үүрэгтэй байх, хаана харьяалагдах зэрэг эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалт дутуу байгааг хэлэлцүүлгийн шатанд анхаарна уу.

6.Төслийн 25.1-д Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэргэжил арга зүй, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн гэж заасан. Төслийн энэ заалтаас үзэхэд төрийн захиргааны байгууллагын оноосон нэр нь Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага болон өөрчлөгдөхөөр байна. Энэ тохиолдолд Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтад нэршилтэй холбогдуулан өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцүүлгийн явцад анхаарна уу.

7.Төслийн 10.1, 11.2, 16.1 дэх хэсгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бичвэрийн агуулга болон хэл зүйн найруулгад тавих шаардлагыг нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй байна.

Ерөнхий хоёр.Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд нь төслийн зохицуулалттай уялдсан эсэх, нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хууль, тогтоолын төсөл нь тухайн хууль, тогтоолын зохицуулалт, зорилго, үндсэн зарчимтай нийцсэн эсэх, шаардлагатай бусад хуулийг бүрэн хамруулсан эсэх талаар. 1.Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан тусгайлан өгөх дүгнэлтгүй болно.

2.Бусад хуулийг бүрэн хамруулсан эсэх хүрээнд дор дурдсан хуулиудыг хуулийн төсөлтэй нийцүүлэх, нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтийг хийх нь зүйтэй байна. 1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.34-д Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн тухай хуулийн 12.3-д заасныг эшилсэн хэсгийг. 2.Биеийн тамир, спортын тухай хуулийн 4.1.22, 24.2-т заасан стандартчилал, үнэлгээ нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн гэснийг, 36.2-т Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасныг эшилсэн хэсгийг. 4.Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 4.4-д заасан Газрын тос боловсруулах үйлдвэр болон, 4.4-д Стандартчилал, техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 25.3.2-т заасныг эшилсэн эсэхийг, Кино урлагийг дэмжих тухай хуулийн 7.1.3-д мөн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасныг эшилсэн эсэхийг хуулийн төсөлдөө нийцүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт санал. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хурал, чуулганаар хэлэлцүүлэх шатад хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах шаардлагатай гэж үзлээ.

2.Төслийг батлах тохиолдолд төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй холбогдох бусад хуульд шаардлагатай өөрчлөлтийг тусган хамт батлах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана гэж үзлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд, Сүхбаатарын Батбаатар Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга, Сэр-Одын Ням-Эрдэнэ Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга, Баярсайханы Ууганбаяр Стандарт, хэмжил зүйн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Гансүхийн Тулгаа Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ваанчигийн Ганзориг Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга, Доржрагчаагийн Бэхбат Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын дарга, Доржийн Эрдэнэтуяа Стандарт, хэмжил зүйн газрын Нийслэлийн Лабораторийн дарга, Гомбодоржийн Батзориг Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сэр-Одын Оюунцэцэг Стандарт, хэмжил зүйн газрын Хууль, эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга, Чулуунтогтохын Содном Стандарт, хэмжил зүйн газрын Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн дарга, Довдоннямын Баярцэнгэл Стандарт, хэмжил зүйн газрын Хууль, эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Дашнямын Даваасүрэн Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Ганчулууны Оргил, Оюунболд Монголын хуульчдын холбооны Тамгын газрын судалгааны төвийн эрхлэгч.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Улсын Их Хурлын гишүүн Мандхайгаар тасалж байна. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ хууль дээр энэ сая Улсын Их Хурлын Тамгын газрын гаргасан дүгнэлт дээр ч байна л даа. Энэ нөгөө стандартын байгууллага маань өөрөө ингээд нөгөө төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх тухай гээд оруулчихсан байна гээд 26.1.8 дээр гээд. Гэтэл болохоор одоо эдгээр үйлчилгээг нь хувийн хэвшил хийж байгаа. Бид чинь бодлогоороо хувийн хэвшлийн хийж байгаа юмыг төр хийхгүй гэж яриад байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийн үзэл баримтлал дээрээ энэ аль болох хувийн секторын хийж чадах ажлыг төр хийх асуудал оруулж тусахгүй байх нь зөв болов уу гэсэн ийм санал байна 1 дүгээрт. Тэгээд яагаад ингэж оруулж ирж байгаа вэ гэдгийг үндэслэлийг нь сонсмоор байна 1 дүгээрт?

2 дугаарт болохоор энэ 14-ийн энэ тохирлын үнэлгээний байгууллага гээд яригдаад байгаа. Ингэнгүүт тохирлын үнэлгээний байгууллага нь болохоор өөрөө Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь өөрөө хийхээр ингээд бас яригдаад байна. Тэгэхээр энэ тохирлын үнэлгээний байгууллага гэдэг чинь болохоор бол бас л хувийн секторын хийж чадах ажил байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ажлыг ингээд Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага нь өөрөө хийгээд байгаа нь хэр зөв юм бэ? Энэ дээр би яг Монгол Улсын барьж

байгаа бодлоготой зөрчилдөж байна гэж үзэж байгаа. Тийм учраас энэ дээр тайлбар авъя.

Р.Сэддорж: Ажлын хэсэг гараа өргөөрэй, 7 номер, өөрийгөө танилцуулаад хариулъя.

С.Батбаатар: Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга Батбаатар байна. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Энэ тарифын асуудал, үнэ тарифын асуудал энэ дээр хөндөгдөж байна. Стандартчилал, хэмжил зүйн газар дэлхийн 16 байгууллагын гишүүнчлэлээр ажилладаг. Энэ дотор олон улсын ISO-гийн байгууллага, цахилгаан техникийн хороо, Ази номхон далайн хэмжил зүйн хүрээлэн гэх мэтчилэнгээр маш олон байгууллагын гишүүнчлэлтэй ажилладаг, олон улсын конвенцыг хэрэгжүүлж байгаа ийм байгууллага. Тэгээд энэ конвенцынхоо хүрээнд бид энэ холбогдох чиглэлийн дагуу энэ стандартыг зарж борлуулах, хэмжил зүйн хэрэгслийг шалгаж баталгаажуулах чиглэлээр үнэ тарифын асуудал энэ хууль дээр орж өгсөн байгаа. Одоогийн хууль дээр ч гэсэн энэ бол үнэ тарифын асуудал хүчин төгөлдөр гээд үйлчлээд явж байгаа гэдгийг хэлье.

2 дугаар асуудлаар тэр тохирлын үнэлгээний байгууллага би эрхэм гишүүн Соронзонболдтой бол санал нэг байдаг. Ер нь хувийн хэвшил хийчих энэ тохирлын үнэлгээний байгууллагуудыг энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд буюу хувийн хэвшил хийх тийм бүрэн боломжтой болчихвол Стандартчилал, хэмжил зүйн газар бол энэнээс чиг үүргээ бага багаар энийг шилжүүлэх тийм бодлого барьж ажиллаж байгаа. Манайх хамгийн эхний шийдвэр гарсан нь ISO 9001 гэдэг энэ стандартыг хувийн хэвшлийг хийх чиглэлээр манайх тушаал гаргаад, одоо энэ хувийн хэвшил бол ISO 9001-ийг хэрэгжүүлээд явж байгаа.

Энэ тохирлын үнэлгээний байгууллагын энэ орлого олж байгаа чиг үүргийг яагаад хувийн хэвшилд бүрэн шилжүүлж болохгүй юм бэ гэдэг асуудал бол манайх 21 аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа. 21 аймагт үйл ажиллагаа явуулж байхад манай Монгол Улсын хэмжээнд 46-хан тохирлын үнэлгээний байгууллага байдаг. Одоо бүрэн энэ төрийн байгууллагын хэрэгжүүлж байгаа энэ чиг үүргийг шилжүүлбэл 21 аймагт тохирлын үнэлгээний байгууллага байдаггүй. Тэгээд энэ чиг үүрэг бол ингээд хууль тогтоомжийн хүрээнд энэ тасалдах ийм болзошгүй байдалтай байгаа учир энэ чиг үүргийг манайх ингээд хэрэгжүүлээд явж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Стандартчилалтай холбоотой шинээр боловсруулагдаж байгаа хуулийн төсөл дээр үндсэн үзэл баримтлалыг нь түрүүлж асуумаар санагдаж байна? Бид төрийн хүнд суртлаас гаргаж, бизнес эрхлэгч нараа дэмжинэ гэж ярьдаг хэр нь яг энэ стандарт, тохирлын гэрчилгээ, энэ үнэлгээ гэх мэт зүйлүүдээр хувийн хэвшлээ дандаа дарамталсаар ирсэн. Тэгээд шинээр боловсруулагдаж байгаа энэ хуулийн төсөл дээр миний харж байгаагаар ахиад энэ төрийн дарамт чинь ороод ирчихсэн байгаа юм биш үү гэж харагдаж байна л даа. Стандартчиллын техникийн хороо гээд 15 хүн сонгон гаргана гэж байгаа юм. Тэгээд тохирлын үнэлгээ хийлгэнэ. Тохирлын үнэлгээний байгууллага гэж тусдаа байгаа, тохирлын гэрчилгээ олгож байгаа юм, баталгаажуулалтын байгууллага гээд. Байгууллага болгоноо тусад нь ингэж гаргаж өгсөн нь зөв зүйтэй юм шиг харагдаж

байгаа хэдий ч энэ маань өөрөө бодит амьдрал дээр хүрээд ирэхдээ бизнес эрхлэгч нарт маш хүндрэл суртал болдоггүй.

Бид нэг стандарт батлахын тулд хойно нь ямар хүнд суртал, хүнд үйл ажиллагаа болдог гэдгийг мэднэ. ISO, EN стандартуудыг нэгийг харьцах нь нэгээр орчуулаад шууд хэрэглэнэ гэж байгаа ч гэсэн Монгол Улсад өнөөдөр яг мэргэжлийн яг хэл найруулга дээр нь Монгол хэл дээр орчуулах яг тийм мэргэжлийн улсууд нь байдаггүй, олддоггүй. Дээрээс нь энийг гаргаад хувийн хэвшлийнхэн өөрсдөө бараг 1, 2 жилийг зарцуулаад, энэ төслөө боловсруулаад гаргаад ирэхэд яг үнэхээр энэ техникийн хороон дээр нь тухайн төслийг нь ойлгож мэддэг хүн ч мэргэжлийн хүмүүс нь байдаггүй. Тэгээд энэ асуудал маань өөрөө сүүлдээ авлигал болж хувирдаг.

Дараачийн нэг асуудал нь бид энэ олон улсын өндөр дүнтэй стандартуудыг үндэсний хэмжээний стандарт болгох гэж оруулж ирэхэд гол нь манайд лабораториуд нь угаасаа байдаггүй. Тэгэхээр энэ нэг өөрөө өөрсдийгөө хуурсан ажлыг хийх гээд ахиад энэ алдаа маань өөрөө засагдаагүй орж ирж байгаа юм шиг харагдаж байна. Тэгэхээр энэ өмнө нь Мэргэжлийн хяналт дээр байдаг байсан одоо Стандарт, хэмжил зүйн газар дээр байгаа. Энэ нэг бид угаасаа хяналтаа төр тавьж чадахгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нэг зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Бид энэ дээр арай нэг өөр өнцгөөс л харах шаардлагатай байна гэж харж байна л даа. Тэгээд энэ олон байгууллагууд чинь бүгдээрээ хувийн хэвшил дээрээ ахиад л нэг гэрчилгээ авна, ахиад нэг үнэлгээ авна гээд. Тохирлын гэрчилгээг өмнө нь 3 жилээр авдаг байсан бол одоо 1 жилээр болгоод гаргачихсан. Энэний шалтгаан нь юу юм бэ? Ингээд улам л төрөөс ямар нэгэн зөвшөөрөл авдаг зүйлүүдээ цаг хугацааг нь ойрхон болгоод, тоог нь нэмээд байгаа хандлага харагдаад байна.

Р.Сэддорж: Шадар сайдын микрофоныг нээе.

С.Амарсайхан: Цэнгүүн гишүүний асуулт бас анхаарах зүйлүүд байгаа энэ хууль дээр. Цаашаа хэлэлцүүлгийн явцад засах сайжруулах зүйлүүд ч байгаа байх. Ер нь Монгол Улсын хувьд манайх өөрөө Стандарт, тохирлын үнэлгээний олон улсын энэ гэрээ конвенц, эрх зүйн зохицуулалт, үүрэг хариуцлага нь олон улсын худалдаа, тэр дундаа бараа, бүтээгдэхүүний энэ чанар, аюулгүй байдал, дотоодын хууль тогтоомжийн уялдааг хангах ийм үүрэг хүлээсэн байдаг. Тэгэхээр энэ агуулгаараа бид аль болох олон улсын хууль, мөн гэрээ конвенц, түүнээс гадна дотоодын хууль журмаа илүү иргэдэд ээлтэй бөгөөд нээлттэй, ямар нэгэн хүнд сурталгүй байх талаас нь харж байгаа. Энэ Стандартын хуульд шинэчлэлд оруулж байгаа, цааш нь өөрчлөлт хийх гэж байгаа гол зорилго ерөөсөө энэ төрийн гүйцэтгэдэг олон шаардлагагүй ажлуудыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх.

2 дугаарт нь зөвшөөрөл нэртэй баахан хэрэгтэй, хэрэггүй цаас цуглуулаад, төрийг нь үзэж хараад үнэлж, дүгнэхээсээ илүүтэй ширээн дээрээ хийж дарчхаад, тэгээд дуртайдаа зөвшөөрөл өгдөг, дургүйгээ хаядаг, хүнд суртал болдог энийг халъя гэж байгаа юм энэ тогтолцоог. Тэгэхийн тулд стандартыг нь баталчихсан байхад өөрөө тэр стандарт нь шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний нотолгоотой, аюулгүй, чанар стандарт нь хангагдсан байвал стандарт нь зөвшөөрөл байдаггүй, зөвшөөрөл нь өөрөө стандарт нь байдаггүй, энэ стандартаа бүгд нийтээрээ мэддэг, мөрддөг, шаарддаг байх ийм тогтолцоо руу орцгооё гэж ингэж энэ хуулийн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийж, тодорхой болгож, илүү нээлттэй болгоё гэж

оруулж байгаа. Бид өөрсдөө энэ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд дагаж зайлшгүй мөрдөх ёстой стандартууд ч бий.

Түрүүний тэр техникийн хороо, зохицуулах хороод гэдэг зүйлүүд дээр анхаарах асуудлууд байгаа. Мэргэжлийн гэхээсээ илүүтэй яг чаддаг, тэр дундаа туршлагатай эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн илүү чадвартай, илүү мэдлэг мэдээлэлтэй, мэргэжлийн хүмүүсээр энэ стандартын хороодыг бүрдүүлэх зайлшгүй шаардлага бий. Одоогийн хороод бол яг мэргэжлийн гэж байгаа хүмүүс, байгууллагуудаас бүрдэж байгаа. Гэхдээ энийг цааш нь бид энэ зах зээлийнх нь зарчмаар, мөн энэ тогтолцоог нь өөрчилж, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагууд, олон улсын байгууллага, дээрээс нь хөндлөнгийн судалгааны болон төрийн бус байгууллагуудад илүү эрхийг нь шилжүүлэх шаардлагатай гэж үзэж энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа.

Ер нь одоо энэ хуулиар хязгаарлагдсан, орхигдсон, хаягдсан, уялдаа холбоогүй маш олон асуудлууд бий. Өмнө нь ч бид Мэргэжлийн хяналт гэж байхдаа мэргэжлийн гэхээсээ илүүтэй сонирхлын, стандарт гэхээсээ илүүтэй зүгээр хувь хүний үзэл бодлын тийм дүгнэлт шаардлагууд явдаг байсан учраас бизнесүүд боогддог, хаагддаг, хүнд суртал нэмэгддэг. Өнөөдөр ч авлига хэвээрээ бий шүү дээ. Өнөөдөр эмнэлэгт хүүхдээ төрүүлэхийн тулд 4 сая төгрөгийн хахууль өгч байна гээд иргэн уйлаад ярьж байгаа юм. Энэний цаана стандарт байхгүй учраас хүн төрөх, амьдрах, мөн эрхээ эдлэх, эрүүл мэндээ хамгаалуулахад хүртэл хууль бус төлбөр төлдөг болчихсон энэ тогтолцоог бид шинэчлэхийн тулд стандартаа өөрчилье л гэж байгаа юм. Стандартыг зүгээр нэг цаас болгоод ширээн дээр дардаг биш, хүн бүхэн амьдралынхаа соёл болгоё, өдөр тутмынхаа хэвшил болгоё, иргэн бүхэн шаарддаг больё, эргээд өдөр тутмын соёлын, чанарын, аюулгүй байдлын хөгжлийн шалгуур болгоё л гэж байгаа юм. Тэгээд энэ дээр мэдээж засах залруулах юмнууд олон байгаа байх та бүхний.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Батчимэг асуулт асууна.

П.Батчимэг: ЗГ-аас өнөөдөр өргөн мэдүүлж байгаа энэ Стандартчиллын тухай хуулийн төсөлтэй уншиж танилцлаа. Ер нь энэ Монгол Улсад 2024 оны байдлаар 2560 дүрэм, журам Хууль зүйн яамны энэ мэдээллийн санд байдаг. Энэ хуулийн төслөөс харахад бас л 6730 гэсэн энэ стандарт өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна гэж байгаа юм. Энэ бодоод үзэхэд ер нь 6730 стандарт гэдэг бол бүүр хэр хэрээс хэтэрчихсэн тоо л доо. Тэгээд сүүлдээ ер нь энэ Монгол Улс гэдэг чинь ер нь дүрэм журам, стандартын улс болж байгаа юм уу гэдэг тийм бодолд хүрлээ. Энэ олон мянган стандарт өнөөдрийг хүртэл ер нь яагаад ингээд хэрэгжихгүй ийм үлбэгэр сулбагар, ийм дорой, тэгээд энэ төр, хувийн хэвшлийн, аж ахуйн нэгжид дарамт учруулсан дахиад нэг ийм стандарт гарч ирэх болов уу?

Одоо ААН-үүд, хувийн хэвшлийн байгууллага бүүр хөгжлийнхөө шатандаа дэлхийн стандарт ISO 9001-ийн тухай яриад сууж байхад өнөөдөр бүүр 9015, 9022, 5 бүүр олон, олон бүүр дагасан стандартууд бүүр үйлчлээд арваад жилүүд л болж байгаа. Төр өнөөдөр төрийн байгууллага нөгөө стандарт ISO 9001-ийг яриад л сууж байх жишээтэй. Хэтэрхий хоцорч байна, хоцрогдолтой байна. Тийм учраас энэ сая би замын хөдөлгөөний Монгол Улсын замын хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шинээр үүсэж байгаа энэ бичил цахилгаан тээврийн хэрэгсэл суррон, скүүтерийн хуулийг өргөн барьсан. ЗГ-аас ирж байгаа хариу нь энийг дүрмээр зохицуулна. Замын хөдөлгөөний дүрмээр, энэ стандартаар бид энийг

зохицуулчихсан, зохицуулна, зохицуулж болдог гээд ийм хариу ирсэн. Маш харамсалтай байгаа. Тэгэхээр энэ хэрэгждэггүй стандартуудыг яаж цаашид илүү энэ стандартын тухай мэдээллийг бид нарт дахиж өгөх юм бэ? Энэ хуулиар биш, дүрэм журмаар зохицуулах гэсэн энэ хуучирсан сэтгэлгээгээ хэзээ арилгах юм бэ? Энэ нь өнөөдөр амь бөхтэй ингээд оршсоор л байна шүү дээ.

Тэгэхээр энэ стандартуудаас хуулиар зохицуулаагүй харилцааг зохицуулсан буюу хуулиас давсан хэм хэмжээ тогтоосон, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт агуулсан стандартууд бий эсэх талаар ямар нэгэн тийм үнэлгээ хийсэн зүйл байгаа юу? Иргэдийн өдөр тутмын амьдрал, эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоох ийм үр дагавартай хотын стандартуудын тухайд ямар байдалтай байгаа вэ гэсэн асуултад хариулж өгөөч?

Энэ хуулийн төслийн 24 дүгээр зүйлд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар төрийн захиргааны төв байгууллага 25.../минут дуусав/

Р.Сэддорж: Батчимэг гишүүнд 1 минут өгье.

П.Батчимэг: 25 дугаар зүйлд Стандартчилал, тохирлын үнэлгээний төрийн захиргааны байгууллага гэсэн байна. Тэгэхээр энд стандартчиллын асуудал хариуцсан яам байгуулах гээд байгаа юм болов уу? Энэ асуултуудад хариу авъя.

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь бид стандартыг ярих ёстой. Стандарт олон байх, цөөн байх гэхээсээ илүүтэй энэ чанар, аюулгүй байдлын шалгуурын асуудал. Стандарт хэд ч байх боломжтой. Шинэ бараа, бүтээгдэхүүн гарах тусам, үйлчилгээ нэвтрэх тусам тэр өөрөө стандарт болж байдаг учраас. Стандартыг бид тэд байна гэж хязгаарлах боломжгүй. Харин үндэсний хэмжээнд энэ байгаа стандартуудаа шинэчлэх, сайжруулах асуудал маш чухал. Монгол Улсад мөрдөгдөж байгаа энэ 6700 гаруй стандарт өөрөө яагаад шинэчлэгдээгүй гэдэг шалтгаан бол ерөөсөө энэ стандарт гэдэг нэр томъёоноос эхлээд хуучнаар бол энэ стандарт үнэ, Стандартын хороо гэж байсан байгууллагыг 90 оноос хойш эзэнгүйдүүлээд, бааз суурийг нь тараагаад, боловсон хүчнийг нь үнэгүйдүүлээд ингээд хуучин бэлтгэгдсэн боловсон хүчнүүд нь орхигдож, гавьяандаа гарахаас эхлээд олон хүндрэлүүд, асуудлууд үүссэн учраас энэ салбар өөрөө эзэнгүйдэж ирсэн учраас өнөөдөр энэ олон стандартууд шинэчлэгдээгүй, мөрдөгдөөгүй ирж байгаа.

Бид олон улсын маш олон судалгаа, тооцоонуудыг хийсэн. Жишээ нь өнөөдөр Их Британи улсад үндэсний болон олон улсын 38 мянган стандарт мөрдөгдөж байгаа. Канад улсад үндэсний болон олон улсын 13 мянган стандарт мөрдөгдөж байгаа. Бидний нөгөө хөгжлөөрөө тэргүүлдэг гэдэг Канад улс, Англи улсад гэхэд 1901 онд хүртэл Стандартын үндэсний байгууллага гэж байгуулагдаж, стандартыг 1 дүгээрт тавьсан учраас, тавьж байгаа учраас тэр улсууд өнөөдөр хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж, хүлээн зөвшөөрөгдөөд явж байгаа. Канад мөн ялгаагүй. Дэлхийн улс орнуудын бүх стандартын хөгжил, шинэчлэл, мөн дагаж мөрдөх дүрэм журмуудыг хүртэл бид олон жил өөрөөр хэлбэл сүүлийн 2, 3 жил судалж, хэлэлцүүлэг оролцоонуудыг хангаж, олон улсын туршлагуудыг ч судалсан. Ийм судалгааны ажлуудаас гадна Монгол Улс өөрөө олон улсын ISO, тэгээд IEC,

тэгээд кодекс, бүр цаашилбал энэ олон улсын стандартын байгууллагуудын гишүүн орон гэж явдаг.

Тэгэхээр бид цаашаа энэ стандартынхаа асуудлыг үгүй хийх, цөөлөх тухай биш, харин тэр бараа, бүтээгдэхүүн бүхэнд нь мөрдөгдөж байгаа стандартаа илүү эзэнжүүлэх, сайжруулах, хяналттай байлгах шаардлагатай. Хяналт байхгүй учраас, стандарт байхгүй учраас бид ямар хяналт тавихаа мэдэхгүй байна өнөөдөр. Стандартаа хянаж чадахгүй байгаа учраас хэнтэй ямар хариуцлага ярихаа хэлж мэдэхгүй явган хэрүүл, явган яриа болоод дуусаж байгаа. Тэгэхээр бүх зүйлүүд нь хар дээр цагаанаар стандарт нь тодорхой болбол хэн нэгэн албан тушаалтан солигдсон, эсвэл аль нэгэн улс төрийн сонгууль, хэн нэгэн сайд, дарга ирсэн, ирээгүйгээр сэтгэлийн хөөрөл, тухайн цаг үеийн улс төрийн хийрхлээр биш, ямагт мөрдөгдөж байдаг стандарт гэдэг зүйл хэвшиж чадвал энэ улсын хөгжил эзэнтэй, эзэнгүй олон ажил маш хурдан цэгцдээ орно, эмх цэгц бий болно гэж үзэж байгаа. Тийм учраас энэ стандартад асар өндөр ач холбогдол өгч байгаа. Та бүхэн маань энэ чиглэлээр өөрсдөө мэдээлэл, судалгаа нэлээн хийж байгаа байх. Энэ өөрөө аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, барилгын норм, дүрэм журам гээд л өнөөдөр. Бид өнөөдөр барилгын материалд физик шинжилгээ хийж чадаж байна.../минут дуусав/

Р.Сэддорж: Тодруулж асууя. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Мэдээж хуулийг 5 жил тутам сайжруулах зорилготой байдаг. Гэхдээ энэ оруулж ирж байгаа өнөөдрийн хуулийн төслийг эсэргүүцэж, эсэргүүцсэн барьсан юм байхгүй. Ганцхан одоо мөрдөгдөж байгаа энэ стандарт, энэ хэрэгжиж байгаа дүрэм журам, энэ олон мянган хэрэгжиж чаддаггүй энэ үлбэгэр энэ олон дүрэм журам, энэ стандартуудаа цаашид ер нь яаж эмхэлж, Засгийн газар яаж цэгцлэх юм бэ л гэдгийг сонирхож байгаа юм л даа. Тэгээд энэ хуулийн 12.1-д иргэн, аж ахуйн нэгж байгууллага стандартчиллын баримт бичгийг сонгон хэрэглэнэ гэж байсан. Тэгвэл одоо орж ирж байгаагаар иргэн, хуулийн этгээд стандарт, үгүй ээ дагаж мөрдөнө гэж байсныг одоо сонгож хэрэглэнэ гээд ингэж өөрчилж оруулж ирсэн юм.

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Батчимэг гишүүний хэлж байгаа яг зөв. Энэ олон хууль гаргадаг, хуулиа дагасан баахан журам, тэр нь хуулиасаа давсан хууль болж хувирдаг. Маш олон журмуудыг цэгцлэх ажил энэ стандартаар л шийдэгдэх ёстой гэж бодож байгаа. Стандарт нь тодорхой болчихвол хэн нэгэн албан тушаалтныг, аль нэгэн даргын үүд сахиж, хэн нэгэн төрийн байгууллагын хүнд суртлаас болж ажил асуудал нь гацахгүй, тэр стандарт нь цахим, нээлттэй болгоод, тэгээд тэр цахим стандартаа өөрсдөө буулгаж аваад, хэрэгжүүлдэг, хэрэглэдэг байх ийм тогтолцоог бүрдүүлчихвэл энэ олон журмуудын хэрэггүй болно гэж 1 дүгээрт үзэж байгаа. Бид ер нь цаашдаа хуулийн стандартаа ч гэсэн анхаарах ёстой. Хууль хэрэгжүүлэх процессын хууль нь өөрөө стандарттай хүртэл байх энэ асуудлууддаа анхаарах ёстой 1 дүгээрт. 2 дугаарт энэ стандартын.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Стандартын хэрэгжилтийг хангуулах тухай асуудал. Одоо бол стандартыг иргэн сонгож болно гээд. Сонгочихсон мөртөө стандартаа

мөрддөггүй учраас бид өнөөдөр нөгөө эрүүл мэндийн салбар нь ч бахь байдгаараа, аюулгүй байдал, хүнсний салбар нь ч аюултай хэвээрээ, сүүлдээ өвчин зовлон, хорт хавдартаа нэрвэгдээд ингээд дуусах хэмжээнд хүрч байгаа юм. Тэгээд энэ хуулиар юу зохицуулах гэж байна гэхээр нэгэнт Амарсайхан гэдэг хүн нэг стандартыг би хэрэгжүүлнэ гээд сонгож авсан бол тэрийгээ заавал хэрэгжүүлдэг байя л гэж байгаа юм. Стандартаа сонгочихсон бол тэр хэрэгжүүлэх үүргийг нь тодорхой болгоод, хэрэгжилтийг нь хангуулчихвал хэн нэгэн араас нь элдэв ойлгомжгүй асуудал яриад байхгүйгээр аль, аль талдаа хариуцлагаа тодорхой болгоё гэж байгаа юм.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь шийдээд, ажлын хэсэг гараад ажиллах бололцоотой гэж харагдаж байна. Шадар сайд ч гэсэн энийг тал талаас нь бүрэн ярилцах бололцоотой гэж байна. Тэгэхээр өнөөдөр олон нийтэд мэдээлэл хүргэх үүднээс хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна. Ер нь энэ 6525 стандартыг цаг хугацааны хувьд авч үзвэл 2000 он гэх үү, 1990 оноос хойш ер нь хэчнээн стандарт байна вэ? Бид хэдийнхээр Зөвлөлтийн гэдэг юм уу, зах зээлийн шилжилтийн үед батлагдсан ийм стандартууд энэний хэдэн хувийг эзэлдэг юм бэ? Ер нь стандартыг update хийх гэдэг юм уу, шинэчлэх энэ хуулийг гэхээсээ илүүтэй энэ 6500-г шинэчлэх, шаардлагагүйг нь хүчингүй болгох энэ асуудлыг мэргэжлийн холбоотой хийх тийм хөдөлгөөн аян өрнүүлж болох уу? Энэ дээр та юу гэж бодож байна вэ?

Мэргэжлийн холбоодыг нь татан оролцуулаад салбар, салбар нь өөр өөрсдийнхөө асуудлын хэлэлцдэг, тэрийг нь баталгаажуулаад өгөөд, энийгээ нэгдсэн байдлаар мөрдөөд, мөрдөх гэж болдоггүй юм шиг байгаа юм стандарт дээр, стандартыг хангуулах гэж ярьдаг юм байна лээ. Өөрөөр хэлбэл стандарт минимум шаардлага. Тэгэхээр энэ минимум шаардлагаас өсгөж тэр үйлчилгээг эсвэл тэр бүтээн байгуулалтыг хийж болно. Тэгэхээр энэ стандартыг мөрдөх гэж ярихаасаа илүүтэй стандартыг хангуулж ажиллах, стандартын тэр шаардлагад хангаж ажиллах, түүнээс илүү үйлчилгээг үзүүлэх гэдэг энэ концепцоор энэ хуулийн үг, нэр томъёо ормоор юм билээ. Яг мөрдөх гэхихээр хэм хэмжээ болоод хууль шиг болчихоод байгаа юм.

2 дугаарт өнөөдөр 700 орчим хууль, 2500 орчим дүрэм журмаас гадна 6525 гэдэг маань үндсэндээ бараг л хууль болчихоод байгаа юм Шадар сайдаа. Стандартын энэ тохирлын байгууллагыг чинь бараг бага Их Хурал гээд байгаа шүү дээ. Улсын Их Хурлаас мандат авч байж захиргааны хэмжээний акт баталж байхад стандартынхан яаж батлагдсан нь мэдэгдэхгүй баахан стандартууд баталчаж байна гэдэг зүйл байгаа. Нэг талдаа тэр юу шүүмжлэл дагуулж байна гэхээр стандартыг батлах энэ процесс ил тод бус байгаа, яаж явж байгаа нь, батлагдаж байгаа. Тэгэхээр энэ хуулийн маань нэг анхаарах зүйл нь энэ процессыг ил тод болгох, оролцоог нь хангах энэ чиглэл рүү нэлээн хэдүүлээ анхаарал хандуулж өгье гэж би хувь гишүүний хувьд бодож байна.

Тэгээд энэ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэдэг юм уу, евро стандартуудыг шууд нутагшуулчих юм ярьдаг мөртөө их төвөгтэй. Энэ нефтийн үйлдвэрийг барихад хүртэл тусдаа хууль гаргаж байж л ойлголцсон. Уг нь Стандарт, тохирын хууль болон Барилгын хуулийг харахаар болчих гээд байгаа юм шиг мөртөө л салбарынх нь мэдэн будилдаг, энийг ерөөсөө хэрэгжүүлэхээс зайлсхийгээд байдаг. Тэгэхээр энийг бүүр нэг тодорхой болгоод, үнэхээр бид хэд

хүлээн зөвшөөрөгдсөн тэр олон улсын стандартыг шууд мөрдчихмөөр байгаа байхгүй юу. Угаасаа бид хэд нефтийн үйлдвэр барьж үзээгүй, угаасаа бид магадгүй цахилгаан станцуудын шинэ технологийг барьж үзээгүй байхгүй юу. Тэрийг нь шууд авч хэрэглээд, аваад хэрэглээд явчихын оронд бараг л нутагшуулна, орчуулна гээд л 3, 4 жилийн ажлыг яриад ингээд бүтээн байгуулалтын ажлуудыг гацаадаг, саатуулдаг юмнууд байна. Энийг яаж шийдэх вэ? Дээрээс нь яах вэ нэг ийм зүйл байгаа юм. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Хууль санаачлагч Шадар сайд хариулж өгөөч. Энэ НҮБ-ын стандартын зарчим бол стандартыг заавал дагаж мөрдөх бичиг баримт биш. Энэ бол минимум буюу сонгож хэрэглээд энэнээсээ л дээшээ шаардлагыг мөрдүүлэх ёстой гэдэг. Манай хууль маань дагаж мөрдөнө гээд ороод ирж байна. Тэгэхээр энэ яг НҮБ-ынхаа тэр зарчим энэ тэрд нийцэж байгаа юу? Техникийн зохицуулалтыг боол заавал дагаж мөрдөх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүд энэ шинэ хуулийн үзэл баримтлал дээр ер нь хэр нийцэж орж ирж байгаа юм бэ? Жишээ нь барилгын салбар, зам дээр бараг танк явах хэмжээний стандарттай Зөвлөлтийн стандартууд мөрдөгдөөд байдаг. Энэнээсээ бид ерөөсөө хэмнэлт хийж чадахгүй байгаа юм. Технологи сайжраад байдаг, хөнгөн хийцлийн гүүр барьж болохоор байтал стандарт нь ийм юм гээд нүсэр, нүсэр гүүрнүүд барьж байгаа байхгүй юу. Одоо энэ балконууд байна. Галын аюулгүй байдлыг л хангах гэж байгаа гэж байгаа болохоос биш яг үнэндээ хэлэхэд дулаан алдагдлыг хамгийн их хийдэг, үйлдвэрлэсэн дулааныг алдагдуулж байгаа юм чинь нийтийн орон сууцын энэ балкон байхгүй юу. Энийг аваад хаячихъя гэхээр стандарт ийм л гээд байдаг. Тэгээд бид хэд.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 7 номер.

С.Батбаатар: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Стандартын тоо, насжилтын асуудал асууж байна. Тэгэхээр 1961-ээс 90 он хүртэл манай нийт стандартын 6733 стандартын 1154 стандарт нийт стандартын 17 хувийг эзэлж байна. 91-ээс 2000 он хүртэл 750 стандарт буюу 11 хувийг нь эзэлж байгаа. 2001 оноос 2010 он хүртэл 2147 стандарт маань нийт стандартын 28 хувь, 11 оноос хойших 20 он хүртэл 2016 стандарт буюу нийт стандартын 29 хувийг эзэлж байгаа. Тэгээд үлдсэн стандарт нь 21 оноос хойших стандарт ингээд эзэлж байгаа гэсэн ийм статистик тоон мэдээлэл манай дээр байна. Стандарт өөрөө инновац, шилдэг технологийг агуулчихсан байдаг гэдгийг энэ дээр хэлэх ёстой. Стандартыг хэрэгжүүлснээрээ Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах тийм нөхцөл бололцоо хангагдаж орж ирнэ гэдгийг энд дурдах нь зүйтэй байх.

Аль түрүүн Батчимэг гишүүн хэлж байна, тэр тоон асуудал яриад байна. Тэгэхээр Казах манай Бүгд Найрамдах Казакстан улс бол 73 мянган стандарттай, БНХАУ 14 мянган стандарттай, ОХУ 44 мянган стандарттай, Канад улс гэхэд 173 мянган стандарттай, АНУ 200 мянган стандарттай. Яг стандартынхаа тоогоор аваад үзэхээр манай Монгол Улс стандартынхаа тоогоор хамгийн бага улсдаа ордог гэдгийг энд хэлье.

Стандартыг яагаад заавал хэрэгжүүлэх ёстой юм бэ гэдэг асуудал энэ дээр яригдаад байна. Тэгэхээр хамгийн сүүлийн үеийн үзлэгийн асуудал ярья. 2022 онд хийсэн барилга, эрүүл мэнд, хүнсний салбар дээр байсан 2000 гаруй стандартыг

үзлэг хийсэн. Энэ дээр 1100 орчим стандартыг шинэчлэх сайжруулах, шинээр боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Үүнээс ерөөсөө одоогийн байдлаар ерөөсөө 20-хон хувь нь л ингээд сайжирчихсан байж байгаа. Тэгэхээр ингээд цаашдаа бид стандартыг эзэнжүүлэх, стандартыг хэрэгжүүлэх, стандартаар хяналт тавих асуудал зайлшгүй ингээд хөндөгдөөд явж байгаа. Тэгээд өөр юу асуулаа, энэ асуултууд нь ингэж хариулья.

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээс хойш энэ олон улсын стандартын байгууллага цаашилбал энэ олон улсын цахилгаан цахим төхөөрөмж, сүлжээ, эрчим хүчний стандартуудыг мөрдөх, хүнсний аюулгүй байдлын стандартын байгууллага гээд энэ байгууллагуудын дүрэм журмыг хууль тогтоомждоо хэрэгжүүлж, дагаж мөрдөх үүргийг хүлээж ирсэн 1 дүгээрт нь.

2 дугаарт энэ хүрээнд олон стандартууд батлагдсан. Ер нь манай улс ялангуяа 2000, сүүлийн 20 оноос, 2000 оноос хойш олон стандартууд өөрчлөгдөх, шинэчлэгдэх ёстой байсан боловч дөнгөж 30 гаруй хувь нь шинэчлэгдсэн. Цаашаа 60, 70 хувийг нь шинэчлэх шаардлагатай. Ингэж шинэчлэхдээ тэр энэ стандартыг баталдаг мэргэжлийн байгууллагуудыг сая Сайнзориг гишүүний хэлдэг илүү чанаржуулах, мэдлэгжүүлэх, илүү ил тод, нээлттэй болгох тухай асуудал.../минут дуусав/

Р.Сэддорж: Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Би нэр томъёоны тодорхойлолттой холбоотойгоор эхний асуулт бол энэ аюулгүйн тэмдэг гээд биччихсэн байна лээ. Аюулгүйн тэмдэг биш илүү баталгаат байдлын тэмдэг гэж өөрчлөх саналтай байна. Яагаад гэхлээр чанар, эрүүл аюулгүйн, эрүүл ахуйн баталгаат байдал гэсэн нэр томъёог хүнсний стандартад ашиглахаар оруулсан байгаа Хүнсний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдээд. Энэ дээр Хүнсний тухай хуулиар аюулгүйн үзүүлэлт гэдгийг баталгаат байдлын үзүүлэлт гэж өөрчлөхөөр тусгаж оруулсныг та бүхэн хуульдаа анхаарч өгөөч гэж хэлмээр байна.

2 дугаарт баталгаажуулалтын схем гээд 4.1.12 дээр тохирлын үнэлгээнд хамрагдах зүйлийг тодорхойлж, үнэлэх аргачлалыг гэсэн байгаа. Энэ баталгаажуулалтын схем гэсэн ойлголт энэ хуулийн төсөлд 2 удаа л орсон байна. Энэ тодорхойлолт нөгөөх нь 16.2 дээр баталгаажуулалтын байгууллага нь тохирлын үнэлгээг схемийн дагуу гүйцэтгэнэ. Сүүлийн заалт дээр баталгаажуулалтын гэдэг үгийг орхигдуулсан байгаа. Тэгэхээр хуульд нэг удаа орж байгаа бол үүнийг тухайн 16 дугаар зүйлд оруулбал зохистой гэсэн ийм санал байна. Энэ схемийг хэн, хаанаас баталдаг вэ гэдгийг тэр нь зохицуулалт байхгүй харагдаж байгаа. Тэгэхээр энийг тодорхой болгож өгөөч гэсэн асуулт байна.

2-т нь болохоор 5.1 дээр техникийн зохицуулалт дээр хүн, мал, эрүүл мэнд гэсэн байгаа. Одоо бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ковидын үеийн нөхцөл байдалтай холбоотой one health гэдэг том зарчмын тодорхойлолт гарч ирсэн. Энийг бүх бүхий л түвшинд ашиглаж ирж байгаа. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор ч гэсэн ер нь энэ хүн, мал, амьтан, ургамал гэсэн томъёоллыг оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ дээр хүн мал, амьтан,

ургамлын гэсэн ийм нэмэлт зүйлийг оруулж өгөөч, тусгаж өгөөч гэсэн хүсэлтэй байна. Энэ дээр. Дээрээс нь энэ үндэсний болон олон улс, бүс, бүс нутаг, гадаад улсын стандартыг хувиран олшруулахыг хориглоно гээд 12.3-д. Энэ угаасаа байсан заалт. Гэхдээ нэгэнт бид бүх зүйлийг ер нь стандарттай байлгая гэж дэмжиж ажиллаж байгаа. Тэгээд энэ бодлогыг барьж байгаа бол хэвлэж хэрэглэх нь өөрөө чөлөөтэй, үнэгүй байх нь илүү зөв гэсэн бодолтой байна. Яагаад гэхлээр олшруулах дээр стандарт өөрөө шаардлага хэм хэмжээ тогтоосон баримт бичиг байгаа. Гэтэл нэг байгууллага өмчлөөд, зараад байгаа нь өөрөө оновчгүй гэж үзэж байгаа учраас энийг ингэж хувиран олшруулахыг хориглоно гэдгийг өөрчлөх саналтай байна. Энэ дээр нэг тайлбар хариу авъя гэж бодож байна. Энэ тохирлын үнэлгээний дүн 15.7.5 дээр үнэлгээний дүн илэрсэн зөрчлийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Мандхай гишүүн 1 минут өгье.

М.Мандхай: Энэ 15.7.5 дээр холбогдох байгууллага энэ ямар байгууллагыг хэлж байгаа вэ, энийг тодруулах боломжтой юу гэж асуумаар байна? Мөн энэ лавлагаа 17 дугаар зүйл дээр лаборатори гэж орсон байгаа. Энэ дээр лавлагаа лабораторийн асуудлыг оруулж хуульчлах саналтай байна. Энэ зүйл дээр олон улсын холбогдох стандартын дагуу шинжилгээний нэг эсвэл хэд хэдэн үзүүлэлтээр итгэмжлэгдсэн бол лавлагаа лабораторийн чиг үүрэг гүйцэтгэж болно гэж оруулах ийм саналтай байна. Яагаад гэхлээр манай дээр заримдаа ялангуяа хүнсний, малын гаралтай жишээлбэл өвчлөл гарлаа гэж үзэхэд манай дээр лавлагаа лаборатори дээр шинэчилсэн шинжилгээг хэрэв чадахгүй бол олон улсын лаборатори дээр шинэчилдэг тийм ээ. Тэгэхлээр энэ дээр яг тэр энэ саналыг, заалтыг оруулбал ямар вэ гэсэн ийм саналтай байна. Тэгээд ерөнхийдөө санал, асуултыг нь давхардуулаад би.../минут дуусав/

Р.Сэддорж: 7 номер.

С.Батбаатар: Мандхай гишүүний асуултад хариулъя. Аюулгүйн тэмдгийг баталгаат байдлын тэмдэг болгож оруулж өгөөрэй гэж байна. Энийг санал гэж үзлээ. Баталгаажуулалтын схемийн асуудлыг асуулаа. Энэ баталгаажуулалтын схем яг олон улсынхаа зарчмаар явж байгаа, стандартын 1706517025 гэдэг стандартын дагуу бид энийгээ яг баталгаажуулалтын схемээ ингээд зохицуулаад ингээд хууль дээрээ оруулж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Хүн, мал, хүрээлэн буй орчны асуудлыг санал гэж ойлголоо. Стандартыг хэвлэж хэрэглэх асуудлыг үнэгүй болгох асуудал гэдэг яг л аль түрүүний нөгөө нэг олон улсын конвенцтой очоод л тулгарчхаад байгаа. Энэ дээр бид нэг дэвшилттэй асуудал хийсэн нь Стандарт, хэмжил зүйн газар дээр estandard.gov.mn бид энэ жил бүрэн цахимжуулж дууссан. Тэрийгээ ИМонголиа-тэй холбочихсон байгаа. ИМонголиа дээр орвол дурынхаа стандартыг та үнэгүй үзэх эрхтэй. Энэ дээр ерөөсөө үнэгүй, ямар ч стандартыг та ингээд ороод үзсэн тэрийг үнэгүй үзэх эрхтэй. Дээрээс нь олон улсын стандартын 40 хүртэл хувийг бид ингээд үнэгүй үзэх эрхийг чөлөөтэй болгож өгчихсөн. Тэгэхээр та нар ИМонголиа руугаа ороод, estandard.gov.mn рүүгээ ороод бол стандартуудаа чөлөөтэй үзэх боломжтой. Ганцхан хэвлээд гаргахад л тодорхой хэмжээний төлбөр байгаа. Тэгээд бид энийг тодорхой хэмжээнд олон улсынхаа байгууллагатай ярилцаад энэ үнэгүй болгох талаас нь ярилцаж үзсэн. Энэ дээр ерөөсөө энэ одоогоор бол энэ тодорхой шийдэлд хүрч чадаагүй байгаа. Тэгэхдээ яах вэ бид үнэгүй үзэх эрхийг нь ингээд хангаж өгчхөөд байгаа гэдэг асуудал хэлье.

Лавлагаа лабораторийн асуудал хөндөж байна. Энэ бол ёстой маш чухал асуудал. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх байгууллага гэж явдаг. Яг лавлагаа гэдэг нэр нь хувийн хэвшил байна уу, бусад лабораториуд дээр гарсан зөрчил, үл тохирлын хоорондын маргааныг л хагалж байх үүрэгтэй. Боловсон хүчин, чадавх, тоног, төхөөрөмжийн хувьд олон улсын түвшинд хүрчихсэн байх ёстой. Тэгэхэд одоо манай үндэсний хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори зүгээр л сорилтын лабораторийн жишгээр л ажиллаж байгаа асуудал гарч байгаа. Тэгэхээр энэ лабораторийг яаж чадавхжуулах вэ, яаж тэр лавлагаа гэдэг нэртэй нь уяж ажиллуулах вэ гэдэг асуудал бол энэ хууль дээр бүрэн орж өгөх боломжтой байгаа гэдгийг хэлье. Тэгээд 15.7 чинь.../үг тасрав/

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Батбаатар: Энэ холбогдох байгууллагууд, Стандарт хэмжил зүйн газартай холбоотой бүх байгууллагууд дээр энэ дээр нь орж байгаа шүү гэдгийг хэлье. Гаалийн байгууллага, татварын байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам гээд манайхтай холбоотой стандартын тохирлын үнэлгээний чиглэлээр мэдээлэл авах ёстой бүх байгууллагууд энэ дээр орж ажиллаж өгнө, юу мэдээллээ өгнө гэсэн тийм агуулга. Энийг тодруулж өгчихье.

Р.Сэддорж: Амарсайхан сайд нэмж хариулна.

С.Амарсайхан: Сая Мандхай гишүүн маш чухал асуулт асуудал хөндлөө. Энэ one health буюу нэг эрүүл мэнд гэж хэлж болох. Өөрөөр хэлбэл хүн, малын гоц халдварт өвчин, зоонозын өвчин, хүнсний аюулгүй байдал, тэгээд бүр цаашилбал байгаль орчны аюулгүй байдлын асуудлуудыг нэг цонхоор харж, нэг ойлголттойгоор, нэгдсэн зохион байгуулалттай тэр дундаа мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж, илүү ул суурьтай, судалгаа тооцоотой алсыг харсан бодлого гаргах энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүний, Малын эрүүл мэндийн байгууллага гэх мэт энэ байгууллагуудын хамтарсан ийм олон ажлууд, хүнсний аюулгүй байдлын байгууллагууд ч ордог. Манай улс энэ one health-г 2010 оноос хойш хэрэгжүүлж ирсэн. Гэхдээ хангалттай биш байгаа. Хүссэн үр дүндээ хүрээгүй байгаа, нийгмийн ойлголт байхгүй байгаа, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо огт байхгүй гэж хэлж болно.

Р.Сэддорж: Мандхай гишүүн тодруулна.

М.Мандхай: Энэ 4.1.12 дээр дахиад би нөгөө нэг түрүүн дутуу хариулчих шиг боллоо. Баталгаажуулалтын схемийг хэн, хаанаас баталдаг гэдэг нь ямар ч энэ хуульд зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Энэ дээр хариулт өгнө үү.

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Яах вэ бид энэ стандартын баталгаажуулалтын үндсэн ойлголтуудыг бүгдээрээ л мэдэж байгаа. Ялангуяа баталгаажуулалт бол хөндлөнгийн байгууллага тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг чанар стандартыг нь баталгаажуулдаг, нөгөөх нь ер нь үндсэндээ стандарт, баталгаажуулалт, итгэмжлэл, тэгээд тохирлын үнэлгээ гэсэн энэ 3 чиглэлээр, 4 чиглэлээр Стандарт, хэмжил зүйн байгууллагын үйл ажиллагаа явж байдаг. Энэ өөрөө шинжлэх ухааны

үндэс суурь болсон байгууллага. Тэгээд итгэмжлэл гэдэг өөрөө яг итгэмжлэгдсэн байгууллагууд тэр баталгаажуулалтаа ном журмын дагуу бодитой, үнэн шударга хийж байна уу гэдэг л асуудлуудыг төрийн зүгээс хяналтаа хийхийг хэлж байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Баталгаажуулалтыг хэрхэн хийдэг, стандарт тохирлын үнэлгээний асуудлууд тус тусдаа мэт боловч нэгдсэн зохион байгуулалттай, ойлголттой. Хамгийн гол нь хариуцсан байгууллагуудын чиг үүргийг илүү тодорхой болгох ёстой. Хууль дээр ч гэсэн илүү.../минут дуусав/

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль нэг ёсондоо стандартын эко системийн гол зохицуулагч хууль шинэчилсэн найруулгаар өнөөдөр орж ирж байна. Тэгэхээр ер нь өндөр хүлээлттэй байсан маш чухал хуулийг Шадар сайд өргөн барьсан байна. Тэгэхээр Улсын Их Хурал дээр ч гэсэн Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Стандарт, стандартчиллын эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох талаар ажлын хэсэг гараад миний бие ахлаад, бид 6 сарын нүүр үзсэн байна. Тэгээд энэ ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн ер нь гол ялангуяа хүн ам, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай шууд хамааралтай гол үндсэн салбаруудынхаа оролцогч бүх талуудтай ч гэсэн бид уулзалт нэлээн зохион байгуулсан, уулзалт форум зохион байгуулсан.

Үүнээс ямар дүгнэлтүүд гарч байна вэ гэхээрээ ялангуяа тэр дундаа хүнс, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, барилгын салбаруудад оролцогч бүх талуудтай уулзахад үнэхээр стандартын асуудал маш тулгамдсан асуудал байна. Шийдэх маш олон зүйлүүд байгаа юм байна лээ. Тэгэхээр түрүүн ярьж байна л даа. Монголд ойролцоогоор 6700 орчим стандарт байна. Тэр дундаа яг барилга, эрүүл мэнд, хүнс, аялал жуулчлалыг нэмээд энэ салбарыг аваад үзвэл 2000 орчим стандарт байна. Энэ 2000 орчим стандартын бараг 62 орчим хувь дээр нь ямар нэгэн шинэчлэл, шинэчлэх хэрэгтэй эсвэл хүчингүй болгох хэрэгтэй гэж салбарынхан өөрсдөө хийж, дүгнэлтээ гаргасан байгаа юм. Тэгэхээр ер нь бид энэ стандартаа цаашаа эрх зүйн орчныг нь ялангуяа энэ экосистемийн хуулиа маш сайжруулж явах нь үнэхээр зүй ёсны хэрэг. Цаг хугацаа нь болсон.

Харин тухайн салбартаа энэ стандартыг шинэчлэн батлуулахад өөрөө энэ бол маш их хугацаа шаарддаг, санхүүжилт шаарддаг зүйл байгаа юм. Жишээлбэл 1 стандартыг анхнаас нь батлуулах хүртэл энэ чинь 1,5-аас 2 жилийн хугацаа шаардах ийм дүр зураг харагдаж байгаа юм. Нөгөө талаасаа энэ нь маш олон талыг оролцуулна, өндөр санхүүжилт шаардлагатай. Жишээлбэл барилгын салбартай уулзаж байхад барилгын салбар дахь заавал даган мөрдөх норм нормативын сан гэж байдаг. Энийг Барилгын хөгжлийн төв өөрөө хийгээд явдаг. Энэ дээр нь ойролцоогоор жил болгон 7-гоос 8 тэрбум төгрөг төвлөрдөг боловч энэ дээр л нөгөө төрийн оролцоо орохоороо тухайн салбар яамдын Төрийн нарийн бичгийн гарын үсгээр тэр дүн нь гарахаараа ингээд асуудал болоод хувираад байгаа юм л даа.

Тэгэхээр ер нь салбарынхан нэг зүйл дээр нэгдсэн нь энэ тухайн салбар өөрсдийнхөө стандартыг мэргэжлийн холбоод, мэргэжлийн байгууллагуудаараа цаашаагаа хөгжүүлээд явах нь зөв юм. Үүн дээр тэр ялангуяа тэр мөнгөний санхүүжилтийн дүн дээр илүү мэргэжлийн холбоод бие даан институт болж, институтын хэлбэр лүү шилжиж.../минут дуусав/

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн 1 минут.

О.Батнайрамдал: Мэргэжлийн холбоод нь ингээд авч явах нь ингээд зөв юм гээд. Тэгэхээр энийгээ илүү энэ хуулийнхаа хүрээнд ч гэсэн тухайн салбар болгондоо энэ зохицуулалтыг нь хийгээд явах нь зөв харагдаж байгаа юм. Тэгээд түрүүн Шадар сайд ярьж байна л даа нөгөө лабораторийн асуудал. Бид өнөөдөр хүнс дээр ч гэсэн, эрүүл мэнд дээр ч гэсэн юу нь болохгүй байгаагаа мэдэхийн тулд, өнөөдөр бид Улаанбаатар хотын агаарын бохирдол ярьдаг. Гэтэл Улаанбаатар хотынхоо агаар, агаарын бохирдлын бид түгээмэл тархацтай тэр 6 бодисыг хэмжиж чадаж байгаа болохоос биш цаашаагаа хүнд металл руу нарийвчлаад орвол 611 бодис байдгийгаа бид өнөөдөр хэмжиж чадахгүй л явж байгаа юм. Тэгэхээр лабораторийн асуудал энэ эко системийн гол хэсэг нь боловч яг сүүлийн 30 жилийн хугацаанд хөрөнгө оруулалт талаасаа маш хоцрогдож ирсэн юм байна лээ. Тэгэхээр цаашдаа ч гэсэн бид энэ лабораториос авхуулаад, хүний нөөцөөс авхуулаад энэ эко системийг бүрдүүлэгч оролцогч талуудыг илүү анхаарах, энэ хуулийн хэрэгжилтийн цаашдаа хэрэгжилтийн хүрээнд ч гэсэн систем рүү нь ингээд зайлшгүй авч явах ингээд шаардлага байна гэж дүгнэлт дээр гарч байгаа юм л.../минут дуусав/

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Батнайрамдал гишүүн маш чухал асуудлуудыг хөндлөө. Бид энэ стандартыг, хэмжил зүйн салбарыг, итгэмжлэл, тохирлын үнэлгээний асуудлыг цэгцтэй болгож, ойлгомжтой тогтолцоо руу шилжүүлэхийн хамгийн чухал үндсийн нэг нь өөрөө энэ лабораториуд. Бид чанар шаарддаг, аюулгүй байдал шаарддаг. Гэтэл тэр чанар, аюулгүй байдлыг баталгаажуулж байдаг лабораториуд улсын хэмжээнд сүүлийн 30 жил дорвитой хөрөнгө оруулалт хийгдээгүй гэж хэлж болно. Та бүхэн бодоод үзнэ биз. Өнөөдөр зарим аймаг, орон нутаг лабораториудад, хэмжил зүйн байгууллагуудад аль 50 оны center book хэрэглэгдэж байна. 70, 80 жилийн. Олон лабораториуд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа учраас бид малын эрүүл мэндээ ч хянаж чадахгүй, хүний эрүүл мэндээ ч олигтойхон шиг хянаж чадахгүй хэмжээний ийм асуудлууд хаа сайгүй байна.

Малын эрүүл мэнд гэдэг бол хүний эрүүл мэнд, хүний эрүүл мэнд өөрөө нийгмийн аюулгүй байдал, өрсөлдөх чадварын индекс, үндэсний асуудал. Ганцхан салбарыг би дурдъя. Барилгын салбарт 300 гаруй стандарт мөрдөгдөж байгаа боловч шаардлага хангаж байгаа нь дөнгөж 20, 30 хувь байна. Тийм учраас өнөөдөр насаараа үр хүүхдийнхээ ирээдүйг ч барьцаалж байгаад авсан байр орон сууц нь орж, тохижиж амжаагүй байхад дээвэр туурга нь нурдаг, ус, дулаан нь асуудал үүсдэг, эргээд нурж унах, шатах хэмжээнд хүрдэг ийм гамшигт хүрсэн. Бид өнөөдөр барилгын физик шинжилгээгээ хийж чадаж байгаа боловч химийн шинжилгээгээ огт хийхгүй байгаа. Гоё, чамин тавилга хэрэгсэл, обой, засал чимэглэлийн ганган сайхан будаг шунхууд дотроо хэрэглээд байдаг. Ямар тавилга хэрэгсэл, ямар хүнд металл, ямар химийн бодис, ямар хор хохирлыг, хор ялгаруулж байгааг бид мэдэхгүй хэмжээнд өнгө харж, мөнгө үрж, эрүүл мэнд, аюулгүй байдлаа золиосолж байгаа ийм асуудал хаа сайгүй байгаа.

Тийм учраас энэ лабораторийн асуудлууд, эрүүл мэндийн асуудлууд, энэ стандартын асуудлуудыг сүүлийн хэдэн жил яриад зогсохгүй, энэ хуулийн шинэчлэлийг хийж, цааш нь дорвитой өөрчлөлт хийе гэж байгаа. Эрүүл мэндийн салбарт 700 гаруй стандарт мөрдөгдөж байна. Энд бид дүн шинжилгээ хийгээд

үзэхэд 130 стандарт нь л зөвхөн шаардлага хангаж байна гэж байгаа. Эмчилгээ, оношилгооны арга зүй, тэгээд эм, тарианы хэрэглээ, чанар, аюулгүй байдлын шалгуур, цаашилбал орц найрлагад хүртэл юу байх вэ гээд, хэдэн төрлийн орц найрлагатай байх юм хэдэн төрөл болоод нэг үнээр, нэг нэрээр зарагдаж байгаагаа хүртэл хянаж чадахгүй болчихсон ийм эрсдэлүүд бий. Тийм учраас бид энэ илүү эрүүл мэндийн стандарт шаардлагуудаа энгийн, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнээсээ эхлээд 1, 2, 3 дугаар зэрэглэлийн эмнэлэг, шатлал, эмчилгээ, оношилгоо, ямар цаг хугацаанд, ямар үед, ямар хугацаанд, ямар шинжилгээ оношилгоо хийчихсэн, ямар шат дамжлагаар явчихсан байх ёстой гээд.

Бид өнөөдөр амьдрал дээр байгаа шүү дээ. Хэдийгээр бид цахимжиж асуудал арай шинэчлэгдэж байгаа ч гэсэн эмнэлэгт очоод л жижүүрээсээ эхлээд л нэр, овгоо хэлээд л, дахиж нэг эмч нэр, овгийг нь асуусаар байгаад л, дахиж нэг эмч, тасгийн эрхлэгч нь бүр цаашилбал хэдэн эмчид нэр, овгоо, төрсөн он, сараа хэлсээр байгаа гээд нэг өвчнөө давтсаар байгаад л амь аврагдах цаг хугацаагаа алддаг ийм гашуун үнэн гамшиг өнөөдөр манай нийгэмд байсаар л байгаа. 50 минутад, цагийн дотор ямар оношилгоо, эмчилгээ, нарийн үйлчилгээнд орчихсон байх ёстой гэдэг зүйлүүдээ хийж байгаа боловч тогтсон стандарт зайлшгүй дагаж мөрдөх, ядаж ямар эмийг, ямар найрлагатай, ямар цаг хугацаанд өгч байгаа юм гэдгээ хүртэл бүрэн тайлбарладаг эмч, эрүүл мэндийн байгууллага маш ховор байгаа. Энэ бүхнийг л өөрчилье гэж байгаа юм. Хүнсний аюулгүй байдлын асуудал, хүнцэл, цаашилбал ургамал хамгааллын бүтээгдэхүүн пестицидийг бид.../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байгаа юу? Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Манай Байнгын хорооны дарга их дурамжхан үг өгч байх шиг байх шүү. Яах вэ энэ хууль дээр хамгийн сүүлд 2023 онд ажиллаж байсан юм. Энэ бол Зөвшөөрлийн хуультай уялдуулж. Тухайн үед яг энэ орж ирсэн хувилбартай нь нэлээн ойролцоо хувилбар явж байгаад тэгээд одоогийн байгаа Стандарт, техникийн тохирлын хуулийг хэвээр нь үлдээгээд явсан шалтгаан нь юу вэ гэхээр заавал дагаж мөрдөнө гэхээр энэ чинь 6000 стандарт чинь бүгдээрээ шалгадаг, торгодог, хяналт тавьдаг энэ тогтолцоо руу орно гэсэн үг. Тэгээд тэр ерөөсөө тэр зөвшөөрлийн ч шаардлагагүй тэгээд л тэнд чинь ерөөсөө бүгдийг нь торгоод л, хянаад л, ингээд л ийм юм руугаа орчих юм байна лээ.

Стандарт, техникийн тохирол гэдэг маань юугаараа ялгаатай вэ гэхээр стандарт бол сайн дурынх байдаг ер нь дэлхийн олонх оронд. Тэр бол эцсийн хэрэглэгчийн тавьдаг шаардлага байхгүй юу. Жишээлбэл тухайн нэг үйлдвэр Говь үйлдвэр Евро стандартаар ч юмаа хийж болно, Японы стандартаар ч юмаа үйлдвэрлэж болно. Тухайн байгууллага ISO стандарт удирдлагын стандартыг ч нэвтрүүлж болно, хөдөлмөр хамгааллын ISO стандарт ч нэвтрүүлж болно, эсвэл Оросын стандартаараа ч явсан болно. Уул уурхайн салбар дээр ч гэсэн Батнайрамдал гишүүн маш сайн мэдэж байгаа байх. ... стандартаар ч хийж болдог, манайд уламжлал болж байсан Орос стандартаараа ч хийж явж болдог. Тэр бол ерөөсөө нөгөө хөрөнгө, одоо жишээлбэл наад нөгөө уул уурхайн салбар дээр хөрөнгө оруулагч нь ямар шаардлага тавьж байгаа тэрэнд нь нийцүүлж л өгдөг гэсэн үг. Тэгээд бид яг стандарт дээр заавал дагаж мөрдөнө гээд явчихаар нөгөө компанид гарах, эсвэл нөгөө иргэн, аж ахуйн нэгж дээр гарах зардал нь 2, 3 дахин нэмэгдэнэ.

Ингээд манай Монгол Улсын стандарт гээд нэг стандарт дагаад мөрдөөд явчихъя гэж бодъё. Тэгэнгүүт нь тэр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь Европ руу гарч байвал Монгол Улсын стандарт чинь хамаагүй болчхож байгаа байхгүй юу. Япон руу гарч байгаа бол Японы стандартыг л бид барих ёстой. Тийм учраас бид стандартыг бол дагаж мөрдөхөөсөө илүү стандартыг бол сайн дураараа хэрэглэ.

Техникийн тохирлыг Засгийн газрын тогтоолоор л, хуралдаанаар техникийн тохирлоо сайжруулаад явчих боломжтой. Манай Амарсайхан сайдын толгойны өвчин болж байгаа би асуудлыг маш сайн ойлгож байгаа. Гэхдээ тэрийг одоо яг энд сууж байгаа эрхмүүдээр ажлыг нь хийлгэх ёстой. Одоо ярьж байгаа тэр лабораторийн асуудал, тэр сая ярьж байгаа пестицидийн асуудал. Энийг та нар Засаг дээрээ энийг бүгдийг нь хийх боломжтой байхгүй юу. Энэ чинь стандартыг хөндөх ерөөсөө ямар ч шаардлагагүй асуудлууд байгаа. Заавал дагаж мөрдөнө гэдэг юм чинь техникийн тохирлоороо явдаг. Сайн дураараа авч хэрэглэх нь стандартаараа явдаг. Ерөөсөө энэ хуулийн чинь үндсэн үзэл баримтлал нь ийм байсан юм. Одоо тэгээд энийг бүгдийг нь ингээд 100 хувь эргүүлээд л хаях гэж байна л даа. Энэ чинь ерөөсөө бүгдийг нь ингээд хянадаг болно гэсэн үг. Бид уг нь энэ авлигыг бууруулах зорилгоор ингээд оруулж ирж байгаа юм шиг боловч яг тэр дунд шат дээр очоод авлигыг энэ 2000 төрлийн, энэ 6000 стандарт бол 6000 төрлийн авлигыг, авлигал өгдөг шалтгаантай л болно гэсэн үг. Тэгээд энийгээ нэг эргэж хараарай хэлэлцүүлгийн явцад.

Р.Сэддорж: Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Стандартыг бид бүр хэрэгжүүлэх гэж байна, хийх гэж байна гээд бүр хүндрүүлэх гэж байгаа асуудал байхгүй. Манай Ганхуяг гишүүн Зөвшөөрлийн хуулийн тухай асуудлыг санаачилж, оруулж батлуулахдаа энэ дээр ярьж байсан, анхаарч байсан асуудал. Ер нь яах вэ стандарт, тохирлын үнэлгээ хоёрынхоо ялгаа салгаа, ач холбогдлыг ангилж ялгаж, ойлгуулах зайлшгүй шаардлага бий. Стандарт өөрөө хүнд суртал байх ёсгүй. Стандарт асуудлыг шийддэг, ажил, амьдралын аюулгүй байдал, хөгжлийн шалгуурыг хангадаг л байх ёстой гэж үзэж байгаа юм. Нэг стандартаа сонгож авах тулгаж байгаа асуудал байхгүй стандартыг. Хэрвээ стандартаа сонгож авсан бол тэр стандартаа хэрэгжүүл л гэж байгаа юм. Мэдээж өөрөө стандарт зардал шаардана, цаг хугацаа шаардана. Стандартаа мөрдөнө гэдэг өөрөө бид нийгмийн аюулгүй байдлаа хангана л гэсэн үг.

Өнгөрсөн жил яг л бид энэ ч хөөрхий, тэр ч дэмий байх гээд дундуур нь нөгөө хяналт нэртэй авлигал хээл хахуулийн асуудал ороод, хүнд суртал бий болсон учраас тэр хүнд суртлын ч арилгая, зөвшөөрөл гэдэг шаардлагагүй асуудлуудаа ч цэгцэлье. Тэгэхдээ төрийн хяналтаа тодорхой больё гэж байгаа юм. Төр гэж байгаад, улс гэж байгаад хүн ам гэж байгаа бол аюулгүй байдал 1 дүгээрт тавигдах ёстой. Төрийн хяналтыг огт үгүйсгэж болохгүй. Тэр бол нийт ард түмний нийтлэг эрх ашиг, аюулгүй байдлын төлөө, иргэн хүний амь, амьдралын аюулгүй баталгааны төлөө тавих хяналт хэзээ ч суларч болохгүй. Гэхдээ хяналтыг мэргэжлийн байгууллага нь ил тод, нээлттэй хийх ёстой. Энэ тогтолцоо руу оруулъя гэж байгаа юм.

Одоо бид зардлаа хэмнээ гэж явсаар байгаад харамч хүн 3 төлнө гэдэг шиг хэний ч шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, эргээд бизнес нь ч дампуурдаг, иргэд нь ч хохирдог, зах зээл нь ч тэлдэггүй, гадаад ертөнцөд ч

үнэлэгддэггүй энэ байдлаа больё гэж байгаа юм. Мэдээж бүх юм үнэ мөнгөөр хэмжигдэхгүй. Стандарт өөрөө аюулгүй байдлаар л хэмжигдэх ёстой. Ийм л асуудлыг бид энэ хуульдаа илүү тусгаж өгч байгаа. Тэгээд хуулийн хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг Батнайрамдал гишүүнээр ахлуулсан манай олон гишүүд ажлын хэсэгт орсон байгаа. Хэлэлцүүлгийн явцад анхаарч, олон нийтийн хэлэлцүүлгээ хийж, алдаа, оноогоо засах байх гэж бодож байгаа. Анхаарах олон асуудлууд бий. Хэлэлцүүлгийн үр дүнд шинэ санаанууд ч нэлээн гарч ирэх байх. Гэхдээ энэ асуудлыг бид одоо хэрэггүй дээ гэж хаяж болохгүй л ийм цаг үе. Энэ стандартын нөхцөл байдлаа бид үнэлэхгүй явж ирсэн учраас өнөөдөр Монгол Улсын бүх салбар, амьдрал ундуй сундуй айл шиг эмх цэгцгүй, эрээвэр хураавар, эзэнгүй, ажил нь эзэнгүй, эзэн нь хариуцлагагүй, хариуцлага нь хяналтгүй. Тийм учраас гүйцэтгэл, чанар гэдэг юм байхгүй болчихоод байгаа учраас энийгээ төрийн, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч цэгцэд нь оруулъя гэж.

Хэрвээ энэ стандартыг бид ингээд цэгцлээд авчихвал асар богино хугацаанд маш олон зүйлүүд эмх цэгцдээ орж, эзэн нь тодорхой болж, эргээд тооцох хариуцлагатай ийм орчин нөхцөл бүрдэнэ. Тэгэхгүй бол явган хэрүүл, эзэнгүй хариуцлага, чанаргүй гүйцэтгэл ийм зүйлүүд үргэлжилсээр л байх болно.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Шуурхай хэлэлцэх асуудал гарсан тул, санал хураалт явуулахад гишүүдийн ирц бас хүрэхгүй байгаа учраас яг гишүүд асуулт асууж дуусаад, үг хэлэх, үг хэлж эхлэхээр дараагийн хуралдаан хүртэл энэ асуудлыг хойшлуулж байна.

16.41 цаг

Байнгын хорооны хуралдаан түр хойшилж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

